

4

ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОГЧ ХЭНТИЙЧҮҮД

● СҮҮЛИЙН ГУРВАН ЖИЛ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИДТАЙ ХОЛБООТОЙ
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ТОО 75 ХУВИАР БУУРАВ

Бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн - Төрийн албан хаагч бүр бодитой судалгаа мэдээлэлд үндэслэн аймаг, орон нутгийн салбарын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийдэг, төсөл хөтөлбөрийн санал боловсруулж, дэмжлэг авч хэрэгжүүлэх бүхий л бололцоог эрэлхийлдэг мэдлэгтэй, чадварлаг, хариуцлагатай хүний нөөцөөр төрийн албыг бэхжүүлэх үүднээс 2017-2019 онд 246 удаагийн нэгдсэн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 40128 төрийн албан хаагчдыг хамруулж, удирдах ажилтны зөвлөгөөнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулав. Ингэснээр төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг, ур чадвар, сахилга хариуцлага сайжирч, сүүлийн гурван жил төрийн албан хаагчидтай холбоотой өргөдөл гомдлын тоо 75 хувиар буурсан дүн гарчээ.

● 2019 ОНД ТӨРИЙН БҮХИЙ Л ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ИРГЭДИЙН
ОРОЛЦООГ 75 ХУВЬД ХҮРГЭЛЭЭ

Аймгийн удирдлагуудаар ахлуулсан ажлын хэсгүүд сүүлийн хоёр жилд бүх сум, тосгон, хөдөөгийн багт хүрэн ажиллаж, Засгийн газрын болон аймаг, орон нутгийн бодлого шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтийн үр дүнг 27000 гаруй иргэддээ тайлагнан тэдний санал хүсэлтийг сонсож, санал аван эрэмбэлж, 250 орчим асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд 2019 онд “Иргэдийн оролцоот шинэ Хэнтий” төслийг хэрэгжүүлэн бүх сумдын айл өрхүүдийг аравт, хэсгийн зохион байгуулалтад оруулж ажилласны үр дүнд иргэдийн оролцоо аймгийн хэмжээнд 2017 онд 30 хувь байсныг 2019 онд 75 хувьд хүргэв.



Тухайлбал, төслийн хүрээнд аймгийн хэмжээний нийт өрхийг 791 аравт хэсэг, бүлэг, нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулж, 18 сумын 120 чиглүүлэгчдээр дамжуулан иргэдийг төрийн бүхий л шатны үйл ажиллагаа болон ОНХС-ийн үйл ажиллагаанд идэвхтэй хамруулж байна.

● ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ 98 ХУВЬТАЙ ШИЙДВЭРЛЭВ


Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 194 төрийн байгууллагыг өргөдөл, гомдлын хяналтын нэгдсэн программд 2017 онд холбосноор аймгийн хэмжээнд өргөдөл гомдлыг 100 хувь бүртгэж хяналтыг сайжруулснаар, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 2013-2016 онд 80-85 хувьтай байсан бол 2018 оны жилийн эцсээр 96 хувь, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 98 хувь болж өслөө.





● ГАДААД, ДОТООДОД АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРМЫГ БАТЛАН ГАРГАЖ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ БАЙНА

Гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, тайлагнах журмыг аймгийн Засаг даргын 2017 оны А/245 тоот захирамжаар батлан гаргаж, хэрэгжилтийг хангуулж, хяналт тавин ажиллаж байна. Үүний үр дүнд сум, албан байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар албан томилолтоор ажиллах болсон тухайгаа аймгийн удирдлагад тогтмол мэдэгдэж, олон нийтэд тайлагнаж хэвшлээ.



● 187 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИНА

Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор www.khentii.mn сайтыг портал сайт болгон орон нутгаас олгодог тусгай зөвшөөрлүүдийг шинээр олгох, сунгах үйл ажиллагааны материал болон төрийн байгууллагатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авах “Цахим Хэнтий” аппликэйшныг ашиглалтад оруулж Эко, ухаалаг хэлбэрт шилжүүлэв.



Мөн Хэнтий аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн систем OffShare-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 187 төрийн байгууллагад ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих системийг бүрэн ашиглалтад оруулан байнгын хяналт тавин ажиллаж байна.

● ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ, ЦАХИМ СҮЛЖЭЭГЭЭР МЭДЭЭЛЛЭЭ ТОГТМОЛ ТҮГЭЭЖ БАЙНА

Төвийн болон орон нутгийн телевиз, сонин, сэтгүүл, сайт, сошиал зэрэг хэвлэл мэдээллийн бүх сувгаар иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэн ажиллаж байна.

Орон нутагт хамгийн өргөн хандалттай МҮОНРТ, TV9, TV5, Малчин, Өлзий, Нутаг 21, Молор телевиз болон орон нутгийн Хэнтий, Өндөрхаан телевиз, долоо хоног тутмын Хэнтийн мэдээ сонин, khentii.mn, khentiinews.mn, zindaa.mn, zarig.mn, Монголын үндэсний сайтын хөгжлийн нэгдсэн холбооны сайтуудаар аймаг орон нутагт хийгдэж буй үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, холбогдох нэвтрүүлгийг тухай бүр нэвтрүүлэн хөдөөгийн иргэд, малчдыг мэдээллээр хангаж байна. Мөн нутгийн Захиргааны байгууллагаас хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас бүтэн жилээр нэгтгэн нэвтрүүлэг, сонины тусгай дугаар бэлтгэж, 88 багийн иргэдийн нийтийн хурлаар иргэдэд үзүүлж, мэдээллээр ханган ажиллаж байна.



● ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ТАТВАРЫН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ТӨСВИЙН БОЛОН ОНХС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАЖ БАЙНА

Татварын албанд бүртгэлтэй ААН, төсөвт болон төрийн бус байгууллагын тоо 2018 онд 2034 байсан бол өнөөдрийн байдлаар 2206 болж өмнөх оныхоос 8,4 хувиар нэмэгдлээ. Орон нутгийн төсөвт 2019 оны эхний 10 сард 11000.8 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өссөн дүн гарлаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн орлого, зарлагын төсөөлөл, 60.8 тэрбум төгрөгөөр

Хүснэгт	Төрөл	Төлөвлөгөө	Бүтэц	Төлөвлөгөө	Бүтэц	Төлөвлөгөө	Бүтэц	Төлөвлөгөө	Бүтэц
1	Татварын орлого	11000.8	...	...	...	...	...	...	...
2	Төсвийн зарлагын төсөөлөл	60.8	...	...	...	...	...	...	...

батлагдсан төсвийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүртээж, АИТХ-ын төсөв баталсан тогтоолыг шилэн дансанд байршууллаа. Мөн ОНХС-гийн 5,6 тэрбум төгрөгөөр 194 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлуудын төлөвлөгөө, зарцуулалтын талаарх мэдээллийг ОНХС-гийн системд тогтмол байршуулж, ил тод байдлыг хангалаа.

2017-2019 онд орон нутгийн төсөвт 10.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь 2016 оноос 22.7 хувиар өссөн бөгөөд ОНХС-гийн 12.2 тэрбум төгрөгөөр 589 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлуудын төлөвлөгөө, зарцуулалтын ил тод байдлыг хангажээ.

● ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЦАХИМ СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ЯВУУЛЖ БАЙНА

Худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан 42.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 230 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зарласан бөгөөд гэрээ байгуулсан төсөл арга хэмжээний 50 хувьд орон нутгийн аж ахуйн нэгж шалгарчээ.

Зөвхөн 2019 оны байдлаар нийт 31316.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий /Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 35 төсөл арга хэмжээ, Орон нутгийн төсвийн, ОНХСангийн хөрөнгө оруулалтын 76 төсөл арга хэмжээ/ 111 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан урилгыг нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зарлажээ. Нийт гэрээ байгуулсан 26320,3 сая төгрөгийн төсөв бүхий 88 төсөл арга хэмжээний 52 хувьд орон нутгийн аж ахуйн нэгж шалгарч төсөл, арга хэмжээг гүйцэтгэн ажиллаж байна.



● 2019 ОНЫ БАЙДЛААР ХЭНТИЙ АЙМАГ 47 МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧТОЙ БОЛЛОО

Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалтыг орон нутагтаа жил бүр, шалгалтыг жилд 2 удаа зохион байгуулж байна. Үүний үр дүнд 2016 оноос хойш нийт 14 нягтлан бодогч буюу жилд 1-7 нягтлан бодогч мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авч, 2019 оны байдлаар Хэнтий аймаг 47 мэргэшсэн нягтлан бодогчтой боллоо. Мөн дээрх сургалт, шалгалтын үр дүнд 15 нягтлан бодогч 1-4 хичээлд тэнцэж, хөнгөлөлт авсан нь мэргэшсэн нягтлан бодогчийг шинээр тэнцэх чадавх, суурь нөхцөлийг бүрдүүлж байна.



● 4 СУМАНД ЗДТГ-ЫН БАРИЛГА, 9 СУМАНД ШИНЭ БАГИЙН ТӨВ АШИГЛАЛТАД ОРЖ БАЙНА

Энэ жил Галшар сумаас гадна Цэнхэрмандал, Дадал, Дархан сумдад шинээр ЗДТГ-ын барилга барьж эхлүүлсэн бөгөөд энэ онд Цэнхэрмандал, Дархан сумын барилга ашиглалтад орж байгаа бол 2020 онд Дадал, Галшар сумын ЗДТГ-ын барилгууд ашиглалтад орох аж. Мөн Мөрөн, Галшар, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Хэрлэн, Батноров, Баян-Овоо, Дадал сумдад багийн төвүүд баригдаж, төрийн үйлчилгээний анхан шатны нэгжүүд иргэддээ ойр ажиллах боломж бололцоо бүрдэж байна.





4.2. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

● ГАДААД ХАРИЛЦААНААС 10 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТЛАА



Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа жилээс жилд өргөжин тэлж, үйл ажиллагаа нь идэвхжиж байгаа бөгөөд ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар, Буриад улсын Улан-Үдэ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймаг, Хөлөнбуйр хот, Жиансү мужийн Нанжин хот, Тунляо зэрэг хотууд болон гуравдагч орнууд болох БНСУ, Кувейт, Япон зэрэг орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажилласнаар аймгийн хэмжээнд 10 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орлоо.

Түүнчлэн Хэнтий аймаг эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй болон бусад салбарын нийт 247 төрийн албан хаагчдыг гадаадын ижил төрлийн байгууллагуудад туршлага судлуулахад дэмжлэг үзүүлжээ.

4.3. ХУУЛЬ САХИУЛАХ БОДЛОГО

● ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДАД 3 ТЭРБУМ ГАРУЙ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЛЭЭ



Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017-2019 онд улс, орон нутгийн төсвөөс 3 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ. Үүнд, Цагдаагийн газар, ШШГГ, Тагнуулын хэлтсийг шинэ байр барихад дэмжлэг үзүүлснээс гадна Чингис хотыг камержуулж, туулах чадвар сайтай 6 автомашин, нисдэг дрон, драгер, хурд хэмжигч, компьютер техник хэрэгслээр хангалаа. Мөн Цэнхэрмандал сумын нутаг дэвсгэрт шалган нэвтрүүлэх пост, Хэрлэн голын гүүрний иж бүрэн замын хяналтын пост, Дадал сум дахь хэсгийн төлөөлөгчийн байр /кабон/, Хууль сахиулах байгууллагуудын сургалт дадлагын төвийг тус тус ашиглалтад оруулжээ.

● ХЭНТИЙ АЙМГИЙН БҮХ СУМД УЛСЫН БҮРТГЭЛИЙН ОНЛАЙН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОЖ БАЙНА



2017 онд Аймгийн Засаг даргын захирамжаар хүн амын төвлөрөл ихтэй Бор-Өндөр сумыг улсын бүртгэлийн нэгдсэн "ePRS" сүлжээнд холбох холболтын зардал, сүлжээ ашигласны төлбөр болох 9.7 сая төгрөгийг шийдвэрлүүлж, "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК сүлжээнд холбосон. Тэгвэл 2018 онд Аймаг, сумдын удирдлагууд иргэддээ төрийн бүртгэлийн үйлчилгээг ойртуулахад анхаарч, санаачилгатай ажиллан 5 сумыг, 2019 онд "Нэг иргэн-Нэг бүртгэл" хөтөлбөрийн зорилтын хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 10 сумыг тус тус онлайн сүлжээнд холбосноор Иргэний улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг онлайн сүлжээгээр иргэдэд үзүүлэх боломжтой боллоо.

Иргэд улсын бүртгэлийн зарим лавлагаа, үйлчилгээг зөвхөн аймгийн төвөөс авч байсан бол одоо онлайн сүлжээний тусламжтайгаар цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хүртээмжтэй түргэн шуурхай авах, иргэдэд эдийн засгийн хэмнэлт гарах боломж бүрдлээ. Тухайлбал, жилд дунджаар иргэдийн 39.1 сая төгрөгийг хэмнэж, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэнэ гэж албаны эх сурвалж тооцоолжээ.

● КРИМИНАЛИСТИКИЙН ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭГ 2-3 ХОНОГТ ШУУРХАЙ ГАРГАДАГ БОЛОВ



Аймгийн Засаг дарга 2017 онд Шүүхийн шинжилгээний албанд орон нутгийн төсвийн 20 сая төгрөгөөр Шүүх эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмж авч өгснөөр Криминалистикийн үзлэг шинжилгээг өмнө нь 5-10 хоногт гаргадаг байсан бол одоо 2-3 хоногт үзлэг шинжилгээний хариуг түргэн шуурхай гаргаж байна.

● ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ ТӨВ АШИГЛАЛТАД ОРЛОО



Хэнтий аймгийн ШШГА-419 дүгээр Нээлттэй хорих анги 2018 онд иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төвтэй болсон. Уг барилга нийт 220,2 сая төгрөгийн төсөвт өртгөөр баригдсан бөгөөд Орон нутгийн хөгжлийн сангаас 50.0 сая, ШШГЕГ-аас 170,2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Барилгын нэгдүгээр давхарт угтах үйлчилгээ, хорих ангид ял эдэлж байгаа хоригдсон этгээдтэй уулзах ар гэрийг шалган нэвтрүүлэх пост, тоо бүртгэлийн тасаг байрлаж байна. Хоёрдугаар давхартаа Бор-Өндөр сумаас бусад тойргийн шийдвэр гүйцэтгэгч, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх шийдвэр гүйцэтгэгч болон үйлчлэгч нарын албан өрөө, сургалтын танхимыг цогцоор нь шийджээ.

● АРХИНЫ ЭСРЭГ СУРГАЛТАД 12751 ХҮНИЙГ ХАМРУУЛЛАА



Архинаас хамааралтай нийгэмд үүсэж буй сөрөг үр дагавруудыг арилгах, ард иргэдийнхээ амгалан тайван байдлыг хангах үүднээс “Архидалтгүй Хэнтий” хөтөлбөрийг 2017 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

Хөтөлбөрийн хүрээнд Хэнтий аймгийн ЗДТГ-аас “Хэрлэнгийн цэнхэр алс” ТББ-д 19.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан бөгөөд 18 сум 5 тосгон 35 байгууллагын 12751 төрийн албан хаагч, иргэдэд архины хор хөнөөлөөс сэргийлэх сургалт хийж сайн дураараа архины хамаарлаас гарах хүсэлтээ илэрхийлсэн 48 иргэнд 21,1 сая төгрөгийн эмчилгээ хийлгэж, эдгээр иргэдийн 80 гаруй хувь нь архины хамаарлаас бүрэн ангижирчээ. Мөн сайн дураараа архины хамаарлаас гарах хүсэлтэй 150 иргэн эмчилгээ хийлгэсэн байна. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо 2017 онд 18.7, 2018 онд 23.6, 2019 онд 12.6 хувиар тус тус буурчээ.

● “БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 59312 ИРГЭНИЙГ СУРГАЛТАД ХАМРУУЛЖЭЭ



“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” дэд хөтөлбөрийн хүрээнд 2017-2019 онд 246 удаагийн нэгдсэн сургалтад давхардсан тоогоор 59312 төрийн албан хаагчид болон иргэдийг хамруулж, удирдах ажилтны зөвлөгөөнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулснаар төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг, ур чадвар, сахилга хариуцлага сайжирч, төрийн албан хаагчидтай холбоотой өргөдөл гомдлын

тоо 75 хувиар буурлаа. Мөн иргэд анхан шатны хууль зүйн зөвлөгөө мэдээллийг эрх зүйн цахим хөтөч e-khutuch.mn хуудаснаас авч хэвшлээ.



4.4. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО

● ИРГЭН-ЦЭРГИЙН ХАРИЛЦААГ БЭХЖҮҮЛЖ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ЭХ ОРОНЧ ҮЗЛЭЭР ХҮМҮҮЖҮҮЛЖ БАЙНА



Орон нутгийн ард иргэд, хүүхэд залуучуудын дунд “Зэвсэгт хүчний ой”, “Монгол цэргийн өдөр”, Цэрэг спортын “Дөл” тэмцээн, Энхийг сахиулагчдын өдрүүдийг жил бүр тэмдэглэн өнгөрүүлж хэвшлээ. Үүнчлэн хүүхэд залуучуудыг цэрэг эх оронч үзэлтэй болгох үүднээс Ерөнхий боловсролын сургуулиудыг “Дайчин алдрын самбар”-тай болгох ажлыг 80 хувьтай гүйцэтгэж, нийтдээ 24.100.000 төгрөгийг зарцуулжээ.

2019 онд Хэнтий аймагт хоёр удаагийн ээлжит цэрэг татлагаар Зэвсэгт хүчний болон хилийн цэргийн анги салбаруудад сурталчлах ажлыг зохион байгуулж, Батлан хамгаалах бодлого зорилтыг давхар сурталчлах үйл ажиллагааг “Монгол цэргийн нэгдсэн холбоо”, “Монгол хурандаа” ТББ-тай хамтран зохион байгууллаа.

● ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН НЭГДМЭЛ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭВ



Шинээр хэрэгжиж эхэлсэн “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль”-ийн дагуу аймгийн нийт сумдаа 4 хэсэг болгон бүсчилж, 2019 оны гуравдугаар сард Биндэр, Баянмөнх сумдад, зургадугаар сард Батноров, Хэрлэн сумдын төрийн захиргааны албан хаагчид болон ард иргэдэд хуулийн танилцуулгыг хийлээ. Тодруулбал, “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г боловсруулж, батлуулан уг төлөвлөгөөнд томилгоожин үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнд мэдээлэл өгөх, хуулийг сурталчлах ажилд нийт 120 гаруй иргэн албан тушаалтныг хамруулжээ.

Тухайн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг үндэслэн сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулах ажил өдгөө үргэлжилж байгаа аж.

● ЦЭРГИЙН АЛБЫГ 60 ИРГЭН ДҮЙЦҮҮЛЭН ХААЛАА



Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас Засгийн газрын 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ын дагуу 18-25 настай залуучуудыг сонгон шалгаруулж, жил бүр 20, нийт 60 иргэнийг 80 цагийн хичээл, сургуульд хамруулж, сумдад нь хүлээлгэн өгчээ.

Сургалтын зардалд нийт 21.200.000 төгрөгийг зарцуулсан бөгөөд Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэд зургаан сараас доошгүй хугацаанд батлан хамгаалах үйл ажиллагаа, ой хээрийн түймэр, малын гоц халдварт өвчин,

өвөлжилт хүндэрсэн газарт өвс, тэжээл хүргэх, малын тарилга, хорио цээр тогтоосон газарт эргүүл, хамгаалалт зохион байгуулах зэрэг аймаг, сум орон нутгийн удирдлагаас өгсөн үүргийг цаг алдалгүй гүйцэтгэж иржээ.

● НЭГ ӨГҮҮЛБЭРЭЭР..

- Аймгийн Онцгой комисс цаг үеийн байдал, үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан 2017-2019 онд нийт 42 удаа хуралдаж, Гамшгийн эрсдэлийг бууруулах сан, Гамшигтай тэмцэх сангаас нийт 663.3 сая төгрөгийг зарцууллаа.
- Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сурталчилгааны самбар 20ш хийж байршуулж, 3 сая

төгрөг зарцуулж энэ оны гамшгийн хохирол 3 хувиар, гамшгийн эрсдэл 12 хувиар буурлаа.

- Аймгийн Засаг даргын 2018 оны 50 дугаар захирамжаар Батширээт суманд, 2019 оны 81 дүгээр захирамжаар Галшар суманд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулсан бөгөөд Баян-Овоо, Батноров, Биндэр сумдад команд штабын сургууль, нийт сумдад бэлэн байдлын үзлэг нэг удаа зохион байгуулж дээрх арга хэмжээнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 24 сая төгрөгийг зарцуулжээ.
- Аймгийн Засаг даргын 2019 оны А/134 Захирамжаар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 24 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй 2 шуурхай бүлгийг ой, хээрийн түймэр гарах өндөр эрсдэл бүхий Өмнөдэлгэр, Батширээт, Баян-Адрага, Норовлин, Дадал, Баян-Овоо сумдад 18 хоногийн хугацаанд томилон ажиллуулснаар өмнөх оны хохирлоос 30 хувиар буурсан байна.
- Холбооны Бүгд Найрамдах Герман улсад Эрэн хайх аврах, техник хэрэгсэлтэй ажиллах сургалтад 1 алба хаагчийг, БНӨСудан улсад энхийг дэмжих ажиллагаанд 1 алба хаагчийг оролцууллаа.



● ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ 42-Р АНГИ БАЙГУУЛАГДЛАА

Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын харьяа Бэрх хот дахь Гал түймэр унтраах, аврах 42-р анги нь нийт 2 тэрбум 89 сая төгрөгийн төсөвтэй баригдсан бөгөөд ой хээр, объектын түймэр унтраах зориулалтын 2 шинэ автомашинтай, техник хэрэгсэл, төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон нийт 58 албан хаагчийн бүтэц, орон тоотой юм.

Тус анги нь зүүн хойд талын сумд буюу Дадал, Баян-Адрага, Норовлин, Батноров, Баян-Овоо сумдын ой хээрийн түймэр, үер ус, гамшиг ослын үед түргэн шуурхай ажиллах зайлшгүй шаардлагатай үед баруун талын сумдад ч хүч нэмэгдүүлэн ажиллах боломжтой аж.



● БАЯН-АДАРГА СУМАНД ЭРЭН ХАЙХ, АВРАХ САЛБАР, ЖАРГАЛТХААН СУМАНД ЭРЭН ХАЙХ, АВРАХ БҮЛЭГ БАЙГУУЛАГДАНА

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 331 дугаар тогтоолоор Хэнтий аймгийн Баян-Адарга суманд Эрэн хайх, аврах салбар хил залгаа 4 сумын 2453 иргэнд, Жаргалтхаан суманд Эрэн хайх, аврах бүлгийг байгуулснаар хил залгаа 6 сумын 2011 иргэнд гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг шуурхай хүргэх боломж бүрдэх юм.



● ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАРТ АВТОМАШИН ГАРДУУЛЛАА

Гамшиг ослын үед яаралтай тусламж үзүүлэхэд туулах чадвар сайтай автомашин нэн шаардлагатай байдаг. Тиймээс аймгийн Засаг дарга Н.Ганбямба Онцгой байдлын газрын албан хэрэгцээнд зориулж 80 сая төгрөгийн үнэ бүхий Ланд 200 маркийн автомашиныг гардууллаа.

Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 30 сая төгрөгийн үнэ бүхий Пургон авто машин 1 олгогдож гамшигтай тэмцэх чадавх дээшлэв.





● ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАРТ 71 ШИРХЭГ ГАЛЫН НӨМРӨГ ГАРДУУЛЛАА

Аймгийн ЗДТГ-аас Онцгой байдлын газарт 71 ширхэг галын нөмрөг гардуулан өглөө. Тус галын нөмрөг нь галд тэсвэртэй шилэн хөвөнгийн орцтой материалаар хийгдсэн бөгөөд эхлэн гарч байгаа объектын болон ой хээрийн түймрийн үед биеэ далдлан, гал гарч буй орчноос дайжих, мөн эхлэн гарч байгаа галыг дарж унтраахад зориулагджээ.



● БАГАЖ ХЭРЭГСЛИЙН НӨХӨН ХАНГАЛТ, ПАРК ШИНЭЧЛЭЛТ ХИЙВ

Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Баян-Овоо, Батноров, Өмнөдэлгэр сум, аймгийн Онцгой байдлын газруудад нийт 9 нэр төрлийн 25.2 сая төгрөгийн үнэ бүхий ой хээрийн түймэртэй тэмцэх, хүч хэрэгслийн чадавхыг дээшлүүлэх багаж хэрэгслийг олгосон байна. Мөн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, түймрийн тоо хохирлыг бууруулах зорилгоор сум, тосгодын дунд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх уралдааныг зарлаж 11 сая төгрөгийн үлээгч аппаратыг тэргүүн байр эзэлсэн 3 суманд олгосон бол болзошгүй гамшгийн үед эрсдэлээс сэргийлэх зорилгоор сумдад ой хээрийн түймэр унтраах 7040.0 төгрөгийн үнэ бүхий 20 ш үлээгч аппаратыг олгосон.



● АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ АЮУЛГҮЙН НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ, ӨРГӨТГӨХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны /Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай/ 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 220 тн өвс, 119 тн рапсын таримал ногоон тэжээл нийт 339 тн өвс, тэжээлийг бэлтгэн аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд байршуулсан.

Малын нэмэлт тэжээл Царгасыг 2018 онд Батширээт, Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумдад 36.2 га талбайд тариалсан бол 2020 онд Норовлин суманд 5 га талбайд тариалахаар төлөвлөжээ.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД БАТЛАГДСАН 12 ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

№	Хөтөлбөрийн нэрс	Хариуцах хэлтэс
1	Ажилтай орлоготой өрх	НБХ
2	Хэнтийн брэнд	ХОХБТХ
3	Эрүүл мэнд-хөдөлгөөн хөгжил	НБХ
4	Архидалтгүй Хэнтийчүүд	ХЭЗХ
5	Бүх нийтийн эрхзүйн боловсрол	ТЗУХ, ХЭЗХ
6	Мянган нуурын хотгор	ХОХБТХ
7	Манай гудамж-Гэрэлтэй гудамж	ХОХБТХ
8	Сумын шинэ төв	ХОХБТХ
9	Хоршоог хөгжүүлэх	ХОХБТХ
10	Төрөлх нутагтаа бид	НБХ
11	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх	НБХ
12	Чингис хаан брэнд	ХОХБТХ



1. “АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ ӨРХ” ДЭД ХӨТӨЛБӨР

“Ажилтай орлоготой өрх” дэд хөтөлбөрийн хүрээнд 2018 онд 30 сая төгрөг батлагдаж, өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааны ажилд зарцуулсан.



Харин ХХҮГ-тай хамтран 2017-2019 онд тус хөтөлбөрийн хүрээнд зорилтод бүлгийн өрх рүү чиглэсэн 4 хөтөлбөр хэрэгжүүлж нийт 1037 иргэнд 1.8 тэрбум гаруй төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Үүнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 61 иргэнийг хамруулж 164 сая төгрөгийн дэмжлэг, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 251 иргэнийг хамруулж 1.1 тэрбум гаруй төгрөгийн 21066 толгой малаар малжуулсан.

Мөн Гэрээт малчин-өрхийг дэмжих туршилтын хөтөлбөрийг 2018 оноос хэрэгжүүлэн 27 малчин өрхөд 54 туслах малчинг гэрээгээр ажиллуулж байна. Эдгээр

гэрээт малчдын болон ажил олгогч малчдын эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэлд сар бүр улсаас 3,0 сая төгрөг төлдөг. Цаашид гэрээт малчныг 2 жил цалинжуулан ажлын байраар хангаж байгаа ажил олгогчид урамшуулал олгохоор төлөвлөөд байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 3 сумын 108 иргэнийг 121,1 сая төгрөг хөнгөлөлттэй зээлд хамруулсан.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалалт, нийтийг хамарсан ажил, зохион байгуулалттай ажлын байр гэсэн 3 арга хэмжээг хэрэгжүүлэн 563 иргэнд 383.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.



Эдгээр ажлын үр дүнд 2576 байнгын болон түр ажлын байр бий болж, ажилгүйдлийн түвшин 2016 оны хагас жилийн байдлаар 11.3 хувьтай байсан бол 2019 оны мөн үеийн байдлаар 3,8 хувь болж 7.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



2. “ХЭНТИЙН БРЭНД” ДЭД ХӨТӨЛБӨР

Хэнтийн брэнд дэд хөтөлбөрийн хүрээнд 2017-2019 онд нийт 79 сая төгрөг батлагдаж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд 2018 онд “Аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”, 2019 онд Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн зөвлөгөөнийг тус тус зохион байгуулж 122 бизнес эрхлэгчдийг хамрууллаа. ЖДҮЭрхлэгчдэд зориулсан 4 удаагийн сургалт зохион байгуулж 200 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан.



2018 онд “Хэнтийд үйлдвэрлэв” 6 нэр төрлийн бүтээгдэхүүний багцыг худалдаанд гаргасан бөгөөд энэ онд нэмж 6 бүтээгдэхүүний сав баглаа боодлын асуудлыг шийдвэрлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Мөн орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчийн бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлж шинээр ашиглалтад орсон Авто буудалд «Хэнтийд үйлдвэрлэв» бүтээгдэхүүн сурталчлах төвийг нээн ажиллуулж байна.

Аймгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах зорилгоор 140 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг багтаасан “Хэнтийд үйлдвэрлэв” танилцуулга номыг хэвлүүлэн гаргасан бөгөөд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран 25 үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулсан нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэлээ.

МСҮТ-ийн хуучин сургуулийн байранд засвар хийж, цэвэр, бохирын асуудлыг шийдвэрлэн 14 өрөөнд үйлдвэр эрхлэгчдийг оруулах боломжийг бүрдүүлсэн ба одоогийн байдлаар 4 үйлдвэр үйл ажиллагаа явуулж 12 ажлын байрыг бий болгоод байна. Цаашид бизнес инкубатор төв болгохоор зорилт тавин ажиллаж байна.

Үйлдвэрлэл эрхлэгчдийн сав баглаа боодлыг стандартын дагуу болгох, нэг ижил сав

баглаа боодолтой болгох зорилгоор хуванцар сав үлээх, шингэн болон өтгөн зүйл савлах тоног төхөөрөмжийг худалдан авч байрлуулаад байна.



Энэ онд ЖДҮДСангаас 1 тэрбум төгрөг хуваарилагдсан тул иргэдийн дунд нээлттэй төсөл сонгон шалгаруулалт явуулж 15 иргэн ААН-д олгохоор шийдвэрлэсэн. Одоогоор 11 иргэн, ААН-д 651 сая төгрөг олгож 147 ажлын байрыг шинээр бий болгоод байна. 2017-2019 онд сумдын сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 133 иргэн, аж ахуйн нэгжид 851,7 сая төгрөгийн зээл олгож, 274 ажлын байрыг бий болгосон.

Одоогийн байдлаар Хэнтий аймгийн хэмжээнд 287 иргэн, аж ахуй нэгж жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх жилээс үйлдвэр эрхлэгчдийн тоо 7 хувиар өсөж жилийн борлуулалтын орлого 7 тэрбум төгрөг болсон.

Мөн 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн шинээр бий болж, Хэнтийн хунчир, Бэрх тосгоны Бөднө шувууны өндөг зэрэг бүтээгдэхүүнүүд орон нутагтаа төдийгүй улсын хэмжээнд үнэлэгдэх боллоо.



3. “ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛГӨӨН-ХӨГЖИЛ” ДЭД ХӨТӨЛБӨР

“Эрүүл мэнд, хөдөлгөөн-Хөгжил” дэд хөтөлбөрийг нийтийн биеийн тамираар хичээллэгсдийг тогтмолжуулах, өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах гэсэн 3 зорилтын хүрээнд хэрэгжүүллээ. Тус хөтөлбөрийн хүрээнд ОНХС-гаас 2017-2018 онуудад 280 сая төгрөг батлагдсан.

Үүнээс халдварт болон зонхилон тохиолдох өвчлөлийн илрүүлгийг сайжруулах

зорилгоор бүх сум, тосгонд нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулж 25584 хүнийг үзлэг оношилгоонд хамруулж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч, эмнэлгийн ажилчдад ажлын байрны сургалт хийлээ.



Урьдчилан сэргийлэх үзлэгээр 171 БЗДХалдвар, 35 хавдрын урьтал өвчин, 6 төрлийн хавдрын 31 тохиолдлыг эрт үед нь илрүүлэн хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлж байна. Зонхилон тохиолдох буюу цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 2016 оны суурь үзүүлэлттэй харьцуулахад тогтвортой байгаа бөгөөд зүрхний шигдээс 2 тохиолдлоор, цус харвалт 11 тохиолдлоор, элэгний шалтгаант нас баралт 0,8 промилиор тус тус буурсан.

Хөтөлбөрийн зардлаас 2017-2018 онуудад 230 сая төгрөгийг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, багш дасгалжуулагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, томилот, тамирчдын уралдаан тэмцээнд оролцох зэрэг зардалд зарцуулсан.

2017 онд өсвөр үеийн шигшээ баг спортын 11 төрлөөр 272 тамирчин хичээллэж байсан бол 2019 онд 15 төрлөөр 286 тамирчин хичээллэж байна.

2017-2019 онуудад Өсвөрийн шигшээ багийн тамирчид дэлхий, тив, олон улсын тэмцээнээс нийт 11 алт, 16 мөнгө, 5 хүрэл медаль хүртсэн. Мөн УАШ-ээс 44 алт, 58 мөнгө, 110 хүрэл медаль хүртжээ.

Дэд хөтөлбөрийн зардлаас нийтийн биеийн тамирын арга хэмжээнд 2018, 2019 онд нийт 15 сая төгрөг батлагдсан. Энэ хугацаанд нийтийн биеийн тамирын чиглэлээр 70 гаруй уралдаан тэмцээн, үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 16000 гаруй иргэд, олон нийтийг хамруулсан.

Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш нийтийн биеийн тамирын чиглэлээр 3 фитнес клуб, 1 иогийн төв, волейбол, дугуй, бокс, буудлага

болон үндэсний спортын төрлөөр нийт 21 спортын холбоо, 3 спортын клуб шинээр нээгдэн үйл ажиллагаа явуулж байна.



4. “АРХИДАЛТГҮЙ ХЭНТИЙ” ДЭД ХӨТӨЛБӨР

“Архидалтгүй Хэнтий” дэд хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 онд 51.1 сая төгрөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнээс “Хэрлэнгийн Цэнхэр алс” ТББ-д 19.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр 18 сум, 34 байгууллагын 5000 гаруй иргэд, төрийн албан хаагчдад архины хор хөнөөл сэдэвт сургалт зохион байгуулж, архидалтгүй аж төрөх зан үйлийг хэвшүүлэхэд анхааран ажиллаж байна.



Сайн дураараа архины хамаарлаас салах хүсэлт гаргасан 39 иргэнийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн Наркологийн тасагт хэвтүүлэн 21,5 сая төгрөгийн өртөг бүхий хордлого тайлах, сэтгэл засал, дуршил бууруулах /спираль/ эмчилгээ хийлгэснээр 80 хувь нь архинаас бүрэн ангижирсан. Эдгээр иргэдээс 29 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангасан.

Тус хөтөлбөрийн хүрээнд сургалт, нөлөөллийн арга хэмжээг амжилттай зохион байгуулснаар 150 иргэн өөрсдийн зардлаар архинаас гарах эмчилгээнд хамрагдсан.

Эдгээр ажлын үр дүнд 2018 онд эрүүлжүүлэгдсэн иргэний тоо 2264 байсан бол 2019 онд 1196 болж 50 орчим хувиар буурсан. Мөн 2018 онд баривчлагдсан хүний тоо 554 байсан бол 2019 онд 393, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хүн 2017 онд 929, 2018 онд 894, 2019 онд 784 болж тус тус буурчээ.



5. “БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ” ДЭД ХӨТӨЛБӨР

“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” дэд



хөтөлбөрийн хүрээнд иргэд болон Төрийн албан хаагчдын хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх гэсэн 2 чиглэлээр хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус хөтөлбөр батлагдахаас өмнө төрийн албан хаагчидруу чиглэсэн аймгийн хэмжээний сургалтын төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх арга хэмжээний зорилт байхгүй байсан. Иймд тус хөтөлбөр батлагдсанаар 2017, 2018, 2019 онд төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах зорилгоор анх удаа аймгийн хэмжээний нэгдсэн төлөвлөгөө баталсан.



Үүнтэй холбогдуулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 2017 онд 82 удаагийн нэгдсэн сургалтад 10885, 2018 онд 94 удаагийн нэгдсэн сургалтад 15000, 2019 оны 9 дүгээр сарын байдлаар 70 удаагийн нэгдсэн сургалтад 14243 төрийн албан хаагчдыг давхардсан тоогоор хамруулаад байна. Нийт 3 жилийн хугацаанд 40128 төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн бөгөөд үүнд 15 сая төгрөг зарцуулсан.

Түүнчлэн аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 194 Төрийн байгууллага Бүх нийтийн эх зүйн боловсрол дэд хөтөлбөрийн хүрээнд дотогш чиглэсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан албан хаагчдаа тогтмол чадвахжуулан ажиллаж байна. Мөн хөтөлбөр батлагдсантай холбогдуулан удирдах ажилтны аймгийн зөвлөгөөнийг 3 жил дараалан амжилттай зохион байгуулсан.

Иргэдийн хууль эрхзүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 400 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 19184 иргэдийг хамруулсан.

2019 оны 7 дугаар сард ХЗҮХүрээлэнтэй хамтран хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг иргэдэд хүргэх “Эрх зүйн хөтөч” бэлтгэх сургалт зохион байгуулж 18 сум 5 тосгон,

15 байгууллагаас нийт 60 хөтөч бэлтгэсэн. Эдгээр хөтчөөр дамжуулан одоогийн байдлаар 200 гаруй иргэн хууль эрхзүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл авсан байна.

Мөн Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим сан e-khutuch.mn буланг Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд байршуулсан. Үүнд 6.4 сая төгрөг зарцуулсан бөгөөд энэхүү булангаар 150 иргэн үйлчлүүлсэн. Цаашид энэхүү буланг Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр бүх сумдад нээн ажиллуулахаар төлөвлөөд байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд 2018 оноос эхлэн хуулийн байгууллагууд хамтарч нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, иргэдэд шаардлагатай хууль эрхзүйн зөвлөгөөг нэг дороос үзүүлж байна. Үүнд хуулийн 11 байгууллага хамтран 50 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 1500 гаруй иргэдэд үзүүлсэн.

6. “МЯНГАН НУУРЫН ХОТГОР” ДЭД ХӨТӨЛБӨР



“Мянгaн нуурын хотгор” дэд хөтөлбөрийн хүрээнд 2017-2018 онд улс болон орон нутгийн төсвийн 230 сая төгрөгийн хөрөнгөөр Хэрлэн сумын 1-5 дугаар багуудын гэр хорооллын гудамжуудын ус ихээр тогтдог хотгор газруудыг тэгшилж иргэдийн амьдрах орчныг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Хөтөлбөрийн үр дүнгийн хувьд засварлагдсан гудамж талбайд тогтмол засвар арчлалтын ажлыг хийж гүйцэтгээгүйн улмаас дахин хонхор хотгор газрууд үүссэн байна.



7. “МАНАЙ ГУДАМЖ-ГЭРЭЛТЭЙ ГУДАМЖ” ДЭД ХӨТӨЛБӨР

“Манай гудамж-Гэрэлтэй гудамж” дэд хөтөлбөрийн хүрээнд улсын болон орон

нутгийн төсвийн 128 сая төгрөгийн хөрөнгөөр Чингис хотын 32 цэгт цамхагт гэрэлтүүлгийг суурилууллаа.



2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад 10 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий аймгийн төвийн хатуу хучилттай авто замын ажил тусгагдаж гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Тус ажлын хүрээнд 6,4 км хатуу хучилттай авто зам, 27,6 мянган м2 явган хүний зам, 474 ширхэг гэрэлтүүлэг, 12,7 мянган м2 ногоон байгууламж хийгдэнэ. Одоогийн байдлаар нийт ажлын явц 60%-тай байна.

Дэд хөтөлбөр хэрэгжсэнээр Чингис хотын хатуу хучилттай авто замын сүлжээ, гэр хорооллын гэрэлтүүлэг нэмэгдэж, гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт өсч, иргэдийн амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.



8. “СУМЫН ШИНЭ ТӨВ” ДЭД ХӨТӨЛБӨР

“Сумын шинэ төв” дэд хөтөлбөрийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн 2,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Адрага, Баян-Овоо сумдын төвлөрсөн дулаан хангамжийн ажил хийж бүрэн ашиглалтад оруулсан ба Өмнөдэлгэр сумын төвлөрсөн дулаан хангамжийн ажил 85 хувьтай үргэлжилж байна.

Мөн Дархан сумын төвлөрсөн дулаан хангамжийн ажил, Хэрлэн сумын 4-р багийн эрчмийн 60 айлын инженерийн шугам сүлжээний ажлууд тухайн жилийн гүйцэтгэлийн хувьд 80%-тай үргэлжилж байна.



Цэнхэрмандал, Жаргалтхаан, Мөрөн, Баянхутаг, Батноров, Норовлин сумдын төвлөрсөн дулаан хангамжийн системийг “Хангайн илч дулаан” ХХК өөрийн хөрөнгөөр байгуулж ашиглалтыг хариуцан ажиллахаар болж, одоогоор шугамын угсралтын ажлууд дуусаж байна. 2019 оны 10 дугаар сарын 20-оос эхлэн халаалт өгөх төлөвлөгөөтэй байна.

Сумдын нэгдсэн инженерийн шугам сүлжээг байгуулснаар сумын хөгжлийн үндсэн суурь дэд бүтэц болж, агаарын бохирдлыг бууруулах, төсөвт байгууллагын зардлыг хэмнэхэд тодорхой нөлөө үзүүлж байна.

9. ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР



Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 2017-2019 онд нийт 34 сая төгрөгийн санхүүжилтээр дараах ажлууд хийгдсэн. Үүнд Хэнтий аймгийн хэмжээнд бүртгэлтэй байгаа 138 хоршоонд үнэлгээ хийж хоршоодын нэгдсэн мэдээллийн баазыг бүрдүүлж, бодит чадавхыг тодорхойллоо.



“Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчид”-ын зөвлөгөөн, 2 удаагийн сургалт зохион байгуулж, гадаад дотоодын туршлага судлах зөвлөгөөн уулзалт арга хэмжээнд нийт 40 гаруй хоршооны төлөөллийг оролцуулж мэдлэг, арга зүйгээр хангаж ажилласан.

Дэд хөтөлбөрийн хүрээнд хоршооны үйл ажиллагаа идэвхжиж, бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжсөнтэй холбоотойгоор тус салбарт 60 гаруй хүн түр болон байнгын ажлын байртай болсон.

Сумдын СХС болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 10 гаруй хоршоо 60-аад сая төгрөгийн дэмжлэгт хамрагдаад байна.

Малын гаралтай дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих



зорилгоор арьс шир элдэх бага оврын тоног төхөөрөмж худалдан авч Хэрлэн сумын 3 болон 4-р багт хүлээлгэн өгөөд байна. Ингэснээр малын гаралтай түүхий эд болох арьс ширийг зах зээлийг эргэлтэд оруулах, ажлын байр нэмэгдэх зэрэг үр дүн гарч байна.



10. "ТӨРӨЛХ НУТАГТАА БИД" ДЭД ХӨТӨЛБӨР

"Төрөлх нутагтаа бид" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2018-2019 онд ОНТөсөвөөс 90 сая төгрөг, хандив тусламжаар 150 сая төгрөг зарцуулсан.

Үүнд орон нутагт шаардлагатай мэргэжлийн судалгаа, Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг хийж байна. Дээрх 2 судалгааг нэгтгэж, аймгийн хэмжээний шаардлагатай мэргэжлийн судалгаа гарахаар төлөвлөн ажиллаж байна.

2018 онд УИХ-ын гишүүд болон сумдын Засаг даргын зүгээс 40 оюутны сургалтын төлбөрт 50 орчим сая төгрөг, 2019 онд УИХ-ын гишүүн болон аймаг сумын Засаг даргын зүгээс 59 оюутанд 65.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Сум орон нутагтаа хув нэмрээ оруулах хүмүүсийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, орон нутгаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцогчдын тоо 2018 онд 7427 байсан бол 2019 онд 10927 болж өссөн байна.

Уг хөтөлбөрөөс 15 сая төгрөгийн үнэ бүхий үнэлгээний машин авч, урьдчилсан шалгалтыг анх удаа зохион байгуулж, сурагчдынхаа мэдлэгийн түвшинг тогтоож шаардлагатай хичээлүүдээр сургалт явуулсан.

2018, 2019 онд ЭШ-д 800 оноо авсан сурагч болон бэлтгэсэн багш нарыг нийт 11,5 сая төгрөгөөр урамшуулсан. Мөн 750-аас дээш оноо авсан сурагчдыг бэлтгэсэн 11 багшийг нийт 1 сая төгрөгөөр урамшуулсан.



ЕБС-ийн сурагчдыг орон нутгийнхаа

хөгжилд хувь нэмэр оруулах боломжоор хангах зорилгоор 2017 оноос эхлэн Засаг даргын нэрэмжит "Төрөлх нутагтаа бид" илтгэлийн уралдааныг зохион байгуулж, тэдний санал бодлыг сонсож, орон нутагт хэрэгжүүлэх боломжтой санал санаачилгыг дэмжин ажиллаж байна.

Тус хөтөлбөр хэрэгжснээр 2016 онд манай аймаг ЭШалгалтын үнэлгээгээр 21 аймгаас 20 дугаар байранд эрэмбэлэгдэж байсан бол тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2019 онд 2 дугаар байранд орж, 10 хичээлээс 9 нь улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй дүгнэгдсэн.



11. "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ" ДЭД ХӨТӨЛБӨР

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн хүрээнд 2017-2019 онд нийт 80,5 сая төгрөг батлагдсан.

Үүний хүрээнд соёлын ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр 13 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 424 хүн хамруулсан.



Уламжлалт ёс, зан заншлыг сурталчлан таниулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Чингис фестиваль" олон улсын соёл урлагийн наадмыг 2017 оноос эхлэн 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан бөгөөд Монгол, БНХАУ-ын ӨМӨЗО, Казакстан, Франц, ОХУ зэрэг 5 улсын төлөөлөл болох нийт 600-аад уран бүтээлч, ардын авьяастнууд оролцсон.

Хэнтий аймгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагчдын бүтээлийг эмхтгэн "Хан Хэнтий салхи" номыг хэвлүүлж уншигчдын хүртээл болголоо.

Буриад зоны "Алтаргана 2018" бага наадам, ОХУ-ын Эрхүү хотод болсон "Алтаргана-2018" ОУ-ын их наадамд оролцоход дэмжлэг

үзүүлснээр манай аймгийн ардын авьяастнууд 5 төрлөөр тэргүүн байр, 2 төрлөөр дэд байрын шагнал хүртсэн.

2019 онд нэрт бүжиг дэглээч Д.Санжаасүрэнгийн нэрэмжит зүүн болон говийн бүсийн мэргэжлийн бүжигчдийн уралдаант наадмыг Чингис хотод зохион байгуулж 5 аймгийн 260 гаруй бүжигчид оролцсон.

2017-2019 онд Мэргэжлийн урлагийн байгууллагын 26 уран бүтээлч БНХАУ-ын Сечуан, Гуанжу болон ӨМӨЗО-ны Хөх хот, Шилийн гол аймагт зүүн Монгол ардын урлагаа сурталчлан соёлын үзвэр үйлчилгээ, тоглолт зохион байгуулж, харилцан туршлага солилцлоо.

Манай аймагт түүх соёлын үл хөдлөх 6730 дурсгал байдаг. Үүнээс нэн түрүүнд хамгаалах шаардлагатай 3332 дурсгалд гэрээт харуул томилж, нийт дурсгалын 48 хувь нь харуул, хамгаалалттай боллоо.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд АДБ-ийн Хан Хэнтий чуулгын уран бүтээлчид 2018 онд Мэргэжлийн театр чуулгуудын улсын уралдаанд “тэргүүн” байр, 2019 онд ОХУ-ын Улаан-Үүд хотноо зохион байгуулагдсан Т.Е.Гергесовын нэрэмжит олон улсын бүжиг дэглээч, бүжигчдийн ҮИ уралдаант наадамд “тэргүүн дэд” байр, БНСУ-д зохион байгуулагдсан “Wonju dynamic dancing carnival 2019” олон улсын тэмцээнд “тусгай” байрын шагнал тус тус хүртсэн.



12. “ЧИНГИС ХААН БРЭНД” ДЭД ХӨТӨЛБӨР

“Чингис хаан брэнд” дэд хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 онд ОНТХ-ийн 79,0 сая төгрөг батлуулж, 8 арга хэмжээ, 15 үйл ажиллагаа тус тус хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажилласан. Үүнд “Мянганы суут хүн Их Эзэн Чингис хааны өлгий нутагт тавтай морил” уриан дор “Хэнтий аймгийн Аялал жуулчлалын хөгжил” зөвлөгөөнийг анх удаа зохион байгуулж, 100 гаруй зочид төлөөлөгчид оролцсон ба М.Батбаяраар ахлуулан төр хувийн хэвшлийнхнийг багтаасан түр хороог байгууллаа.

Хэнтий аймгийн газрын зургийг дахин шинэчлэн хэвлүүлж ОУ-ын болон дотоодын

аялал жуулчлалын үзэсгэлэн, эвент арга хэмжээнүүдийн үеэр зочид, жуулчдад сурталчлан танилцуулж байна.

Монголын аялал жуулчлалын холбооноос БОАЖЯ-тай хамтран жил бүрийн хавар уламжлал болгон зохион байгуулагддаг “Ай Ти Эм-2018” үзэсгэлэнд оролцож Монголын аялал жуулчлалын холбоотой хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж “ITM-2020” аялал жуулчлалын Олон улсын үзэсгэлэнд түнш аймгаар оролцохоор боллоо.



Хэнтий аймгийн зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудад зориулсан онол практикийн сургалтыг 2 жил дараалан зохион байгуулж давхардсан тоогоор 14 сумын 484 нутгийн иргэд, нөхөрлөлийн гишүүд, өрхийн үйлдвэрлэгчид, үйлчилгээний байгууллагын ажилтан, албан хаагчид хамрагдаж, мэргэжлийн үнэмлэх, сертификат гардан авлаа.

2018, 2019 онд Тогорууны баяр, Галшар адууны баяр, Ёохор хатар, Чингис фестиваль, Монгол тайга нохойн наадам, Талын түмэн адуу зэрэг 6 эвент арга хэмжээг зохион байгуулж 360 гаруй гадаадын, 4700 гаруй дотоодын жуулчид оролцлоо.



Чингис хаан дэд хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээр аймгийн аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, 2019 онд 25.5 тэрбум, 2020 онд 60.0 гаруй тэрбум төгрөгийн УТХО-аар бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Н. ГАНБЯМБА, ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ НАР ИРГЭДИЙН ХАМТ ЧИНГИС ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямба болон Хэрлэн сумын Засаг дарга Ц.Идэрбат нар хамтран Хэрлэн сумын 6 багийн 50 гаруй иргэдийн төлөөлөлтэй хамт Чингис хотын хөгжил дэвшил, шинэ бүтээн байгуулалттай газар дээр нь танилцах экобустай аяллыг зохион байгууллаа.



Уг аялал өглөө 10 цагт Р.Чойномын хөшөөт гэрэлт цэцэрлэгт хүрээлэнгээс эхэлж, аймгийн Цагдаагийн газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, Татварын хэлтэс, Хэрлэн дом шинэ өрхийн эрүүл мэндийн төв, ХХҮГазар, Хан Хэнтий чуулгын барилгын ажил, Нэгдсэн эмнэлэг, Өндөрхаан хот тохижилтын цахилгаан автобусны граж, Шинэ Өндөрхаан хороолол дахь хямд үнэтэй орон сууц зэрэг шинэ барилгуудтай танилцаж, Нэхий боловсруулах үйлдвэр, Бизнес инкубатор төв, Чингис хот доторх явган хүний зам болон гэрэлтүүлэг бүхий шинэ авто зам, Цэвэрлэх байгууламж, Дулааны станцын 2-р хэлхээ, 4160 м цэвэр усны шугам зэрэг бүтээн байгуулангуудаар явж найман цаг үргэлжиллээ.

ФОТО СУРВАЛЖИЛГА



● ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Хэрлэн сумын 5-р багийн иргэн Д.Дэлгэр:

ЧИНГИС ХОТ МААНЬ НҮДЭН ДЭЭР ӨНГӨӨ ЗАСАЖ БАЙНА

Хэнтий аймагт маань, тэр дундаа Чингис хотод маань ийм олон сайхан барилга байгууламж баригдаж, бүтээн байгуулалтууд өрнөж байгаатай газар дээр нь очиж танилцаж явна. Аймаг, сумын дарга нар маань иргэдтэйгээ хамт энгийн сайхан аялаад, хийж бүтээж байгаа ажлуудаа танилцуулаад, тайлбарлаад бодитой мэдээллийг өгч, байгаад талархлаа илэрхийлье. Ийм хэлбэрээр иргэддээ мэдээ мэдээлэл өгөх нь зөв зүйтэй юм байна. Чингис хот маань нүдэн дээр өнгөө засаж байна.



Хэрлэн сумын 3-р багийн иргэн С.Оюунгэрэл:

УЛАМ Л АЯ ТУХТАЙ, ТААТАЙ ОРЧИНД АМЬДРАХ НӨХЦӨЛ БҮРДЭЖ БАЙНА

Өнөөдрийн энэ аялал бол иргэдэд хүрсэн сайхан ажил болж байна гэж бодож байна. Аймгийн Засаг дарга маань иргэд бидний төлөөлөлтэй хамтдаа нэгэн өдөр эко автобусаараа хотынхоо бүтээн байгуулалт, өрнүүлж буй ажлууд дээр газар дээр нь очиж танилцаж, бидэнд мэдээлэл өгч байгаа нь сайхан байна. Их ч бүтээн байгуулалт өрнөж байгаа юм байна. Ёстой л аймгийнхаа төлөө Хэнтийчүүд маань эрвийх дэрвийхээрээ хичээж байгаа юм байна. Харлаа. Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд маань стандартад нийцсэн, шинэ сайхан байруудтай болж. Зам харгуй ч дорвитойхон нэмэгдэж. Улам л ая тухтай, таатай орчинд амьдрах нөхцөл бүрдэж байна.



Хэрлэн сумын 5-р багийн иргэн Г.Хэрлэн-Ундрах:

ИРГЭДИЙНХЭЭ ТӨЛӨӨ ХИЙЖ БҮТЭЭЖ БАЙГАА БҮХЭНД НЬ ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ

Аймгийн бүтээн байгуулалтын ажлууд эрчимтэй сайн явагдаж байгаа. Иргэдийн нүдэнд ил байна. Эгнээ гудамжууд маань очих хаягтай, гудамж талбай гэрэлтэй цэлгэр, зам харгуй нэмэгдсэн, барилга байгууламжууд баригдсан, хэн ч харсан энэ аймаг, энэ хот хөгжиж байгаа, хийж бүтээж байгаа нь ил сайхан байна. Гэрэлт цэцэрлэгт хүрээлэн, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар гээд албан газрууд маань сайхан байртай болжээ. Хан Хэнтий чуулгын урт настай барилга ирэх хавраас ашиглалтад орохоор болсон байна. Дулааны станц, цэвэрлэх байгууламжтай аймаг болох гэж байгаа юм байна. Энэ намраас явж эхэлсэн эко автобуснууд Хэнтий аймагт үгүйлэгдэж байсан нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлээд эхэлчихлээ. Иргэдийнхээ төлөө хийж бүтээж байгаа бүхэнд нь талархал илэрхийлье.



Хэрлэн сумын 5-р багийн иргэн Д.Норов:

ЭКО АВТОБУСНУУДАА НЭМЭХ ХЭРЭГТЭЙ

Бүтээн байгуулалтууд гайгүй сайн хийгдэж байна даа. Эмнэлэг, цагдаа, татвар, халамж, чуулга, стандарт хэмжил зүй, багийн төвүүд гээд албан байгууллагууд маань шинэчлэгдээд, эхнээсээ шинэ байрандаа орцгоогоод сайхан болжээ. Нэгдсэн эмнэлэг маань нарийн тоног төхөөрөмжүүдтэй болж, захын өрхийн эмнэлэгт 8, 9 төрлийн шинжилгээ оношлогоо хийлгэх боломжтой, үйлчилгээ нь ч сайжирсан гээд их аятайхан болжээ. Цахилгаан автобуснууддаа сууж үзлээ. Сайхан байна. Харин чухам яг нийтийн тээврийн үйлчилгээндээ яваад ирэхээр цөөдөөд байх бололтой санагдсан. Тиймээс боломж гарвал эко автобуснуудаа нэмэх хэрэгтэй байна.





Хэрлэн 4-р багийн иргэн Э.Энхмаа:

ЧИНГИС ХОТ МААНЬ ИРЭЭДҮЙД ХҮСЭН ХҮЛЭЭХ САЙХАН ХОТ БОЛОН ХӨГЖИХ НЬ

Гаднаас нь хараад л байснаас орж үзэж, яаж бүтээн байгуулж байгааг сайн мэдэхгүй байсан. Яг өнөөдөр ингээд аймаг, сумын дарга нартай хамт аялаад, ямар төсөв хөрөнгөөр, хэрхэн бүтээн байгуулж байгаатай танилцаад их мэдээлэл авлаа. Чингис хот маань залуус бидний ирээдүйд хүсэн хүлээх сайхан хот болон хөгжих эхлэлүүд хэдийнэ тавигдаж дээ гэж бодогдлоо. Би хорихын байранд амьдардаг. Урд нь овон товонтой эгнээ гудамжинд, шороон замаар, хаяггүй, харанхуй гудамжаар, ийм л нөхцөл байдалд манай үеийн хүүхдүүд өсөж хүмүүжсэн. Одоо харин хүүхдүүд, залуучууд гараад тоглох тоглоомын талбайтай. Шинэ сайхан засмал замтай, гэрэлтэй гэгээтэй үнэхээр гоё болж байгаа шүү. Р.Чойномын гэрэлт цэцэрлэгт хүрээлэн маш их таалагдсан.



Хэрлэн 4-р багийн иргэн Г.Алтанчимэг:

АЙМАГ ӨДРӨӨС ӨДӨРТ ӨРГӨЖИН ХӨГЖИЖ, ДЭВЖИН ДЭЭШЛЭЖ БАЙГААГ ХАРАХАД САЙХАН БАЙДАГ

Манай аймагт их ч хөрөнгө оруулалт орж, их ч бүтээн байгуулалт хийгдэж байгаа юм байна. Гол нь тэр их хөрөнгө зарсан энэ бүтээн байгуулалтуудыг ингэж иргэддээ нээлттэй үзүүлж харуулж, захиалагч, гүйцэтгэгч, хяналт тавигчдынх нь оролцоотойгоор тайлбар мэдээлэл хүргэж, нээлттэй сайхан ажиллаж байгаа аймгийн удирдлагууддаа тэдний хамт олонд баярлалаа. Аймаг өдрөөс өдөрт өргөжин хөгжиж, дэвжин дээшлэж байгааг харахад сайхан байдаг.



Хэрлэн 3-р багийн иргэн Н.Уранцэцэг:

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЯЛЛААС АЙМАГ ОРОН НУТГИЙНХАА БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ БОДИТООР МЭДЭРЛЭЭ

Хэнтий аймгийнхаа бүтээн байгуулалтыг үзэж харлаа. Нөгөө айхтар хотгор гүдгэрүүдийг чинь арилгаад тэгшилчихэж. Зам харгуй, барилга байшингууд таалагдаж байна. Бизнес инкубатор төвд ажлын байрыг нэмэгдүүлэх олон ажил хийгджээ. Талх нарийн боов, артишок үйлдвэрлэж байна. Арьс ширэн эдлэл, гоёл чимэглэл, ноос ноолууран хувцас хүртэл хийж байна. Нэхий боловсруулах, нэхий эдлэл хийх үйлдвэр хүртэл бий болж байгаа юм байна. Манай залуучууд хийж чаддаг, дэмжээд өгвөл илүү олон ажлын байрыг нэмэх, орон нутагтаа жижиг дунд үйлдвэрлэлийг өргөжүүлж хөгжүүлэх боломжтой байгаа нь харагдлаа.



Хэрлэн 3-р багийн иргэн М.Оюунбаатар:

ИРЭХ ХАВАР ХАН ХЭНТИЙ ЧУУЛГА АШИГЛАЛТАД ОРОХООР БОЛСОН БАЙНА

Аймгийнхаа бүтээн байгуулалтуудыг нүдээр үзэж танилцлаа. Хэнтий аймагт олон сайхан бүтээн байгуулалт хийгдэж байгаад баяртай байна. Хан Хэнтий чуулгын барилгын талаар бодит мэдээлэлгүй. Хэзээ ч баригдаж дуусах нь тодорхойгүй байлаа. Өнөөдөр чуулгын барилга юунаас болж царцсан, асуудал хаанаа байсныг гүйцэтгэгч компани, хяналт тавьж буй газрын мэргэжлийн улсууд, аймаг, сумын удирдлагуудаас тодорхой мэдээллийг газар дээр нь авч, танилцаж байна. Иргэд бид аймгийн удирдлагуудыг шүүмжлээд байдаг нь буруу юм байна. Барилга гүйцэтгэгчийн хариуцлагагүй байдлаас болж энэ барилга царцсан юм байна. Ирэх жил зургадугаар сард энэ барилга улсын төсвийн 3 тэрбум гаруй төгрөгийн нэмэлт санхүүжилтээр хүчитгэлийн ажлууд хийгдээд, ашиглалтад орохоор болжээ. Таатай байна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ ХЭНТИЙ АЙМАГТ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, ЭМНЭЛЭГ, СОЁЛЫН ТӨВ ЗЭРЭГ 9 ШИНЭ ОБЪЕКТ БАРИХААР ШИЙДВЭРЛЭЛЭЭ

Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ болон Засгийн газрын гишүүд бусад албаны хүмүүс 5 дугаар сарын 5-аас 10-ны өдрүүдэд Хэнтий аймагт ажиллаж, орон нутагт тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэж байна.

Тухайлбал Жаргалтхаан, Мөрөн, Хэрлэн, Баянхутаг сумдад эмнэлэг, сургууль, цэцэрлэг, соёлын төв, орон нутаг судлах музей, сүрьеэгийн эмнэлэг зэрэг 8 объектыг шинээр барих, мөн боловсрол, эрүүл мэндийн салбарын 9 байгууламжид засвар үйлчилгээ, өргөтгөл хийхээр болсноос гадна шаардлагатай

тоног төхөөрөмж, авто машиныг газар дээр нь гардуулан өглөө.

Мөн Төрийн албан хаагчид, Боловсрол, соёл, спорт, эрүүл мэндийн салбарынхантай уулзалт зохион байгуулж сахилга бат, ёс зүйтэй ажиллах чиглэлээр үүрэг даалгавар өгсөн бол Жаргалтхаан, Мөрөн, Хэрлэн сумын иргэдтэй уулзаж төрийн бодлого шийдвэрийг танилцуулж иргэдийн асуултад хариулт өглөө.

Үргэлжлүүлээд Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсгийнхэн Бэрх тосгон, Батноров, Биндэр, Дадал сумдад ажиллалаа. Үүнд



● ЖАРГАЛТХААН СУМАНД

1. Ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн хүчин чадалтай хичээлийн шинэ байрыг барьж ашиглалтад оруулах
2. Цэцэрлэгийн барилгын засварлах
3. Эрүүл мэндийн төвд туулах чадвар сайтай автомашин олгох
4. Эмнэлгийн барилгад их засвар хийх
5. Эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх
6. Онцгой байдлын аврах бүлэг байгуулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэлээ.
7. Мөн Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх сумын Тамгын газарт гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, ой хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд зориулж, туулах чадвар сайтай фургон автомашиныг гардууллаа.
8. Тус сумын ЗДТГ-аас санаачлан зохион байгуулдаг Жаргалтхаан сумын уугуул, нэрт хөгжмийн зохиолч Б.Шаравын нэрэмжит “Сэрсэн тал” дуу хөгжмийн

наадмыг Засгийн газрын тогтоолоор улсын уралдаан болгож, 4 жилд 1 удаа зохион байгуулахаар гаргасан шийдвэрийг сумын удирдлагуудад гардууллаа.

● МӨРӨН СУМАНД

1. 5 га газрын усалгааны систем байгуулах
2. Нарийн ногоо тарих 3 хүлэмж, трактор олгох
3. 60-70 метрийн гүний худаг барих
4. Соёлын төвийг шинээр барих
5. Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар
6. Ерөнхий боловсролын сургуулийн засварын ажлыг цаг алдалгүй хийхээр болж, хөгжим, өсгөгч аппаратур олгохоор шийдвэрлэлээ.

● ХЭРЛЭН СУМАНД

1. Хэрлэн сумын 1-р арван жилийн 1500 хүүхдийн суудалтай хичээлийн байрыг шинээр барих



2. Сүрьеэгийн эмнэлэг шинээр барих
3. Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийг шинээр барих
4. Орон нутаг судлах музейн байрыг шинээр барих
5. УЦУОШТ-ийн шинэ байрны хөрөнгийг 2020 оны төсөвт суулгах
6. 180 айлыг ипотекийн зээлд хамруулах
7. Газар тариалангийн дунд оврын иж бүрэн трактор олгох, хүлэмж барих
8. Өлзийт тосгонд эмнэлгийн барилга шинээр барих
9. Тахилгат тосгоны эмнэлгийн засварын 162 сая төгрөгийн асуудлыг тус тус шийдвэрлэж эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай байгаа эмнэлгийн тоног төхөөрөмж, түргэн тусламжийн 2 авто машин гардууллаа.
10. Мөн Улсын төсвийн 10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Чингис хотын 10,2 км хатуу хучилттай авто зам, явган хүний замын төслийг танилцуулах арга хэмжээ, Чингис хот – Дадал чиглэлийн "Түүхэн аялал жуулчлалын авто зам"-ын бүтээн байгуулалтын нээлтийн ажиллагаанд тус тус оролцож, Хэнтий аймгийн ууган сургууль болох Хэрлэн сумын 1-р дунд сургуулийг Төрийн дээд алтан гадас одонгоор шагналаа.

● БАЯНХУТАГ СУМАНД

1. Сумын төвийг нэгдсэн халаалтад холбох
2. Цэцэрлэгийн өргөтгөл хийх
3. Эмнэлгийн өргөтгөл, эмчийн байрны их засвар
4. Эмнэлэгт нэн шаардлагатай тоног төхөөрөмж шинээр олгох
5. Соёлын төвийн сандлыг бүрэн шинэчлэх
6. ЕБС-ийн урлаг заалны засварын ажлыг хийхээр шийдвэрлэлээ.

● БАТНОРОВ СУМАНД

1. Сургуулийн өргөтгөлийн барилга Бэрх тосгонд
2. 5.7 тэрбум төгрөгийн өртөгтэй шинэ дулааны станц

● НОРОВЛИН СУМАНД

1. Шинэ соёлын төв барихаар хуучин соёлын төвийг ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглахад 50 сая төгрөг шийдвэрлэв.
2. Мөн Төрийн албан хаагчид, Боловсрол,

соёл, спорт, эрүүл мэндийн салбарынхантай уулзалт зохион байгуулж сахилга бат, ёс зүйтэй ажиллах чиглэлээр үүрэг даалгавар өгсөн бол Жаргалтхаан, Мөрөн, Хэрлэн сумын иргэдтэй уулзаж төрийн бодлого шийдвэрийг танилцуулж иргэдийн асуултад хариулт өглөө.

3. Үргэлжлүүлээд Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсгийнхэн Баян-Адарга, Дадал сумдад ажиллалаа.

● ЕРӨНХИЙ САЙД ДАДАЛ, БАЯН-АДАРГА СУМАНД АЖИЛЛАЛАА

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхээр ахлуулсан Засгийн газрын танхимын зарим гишүүд, аймгийн удирдлагууд Дадал сумын нисэх онгоцны буудалтай танилцлаа.



Энэ үеэр Ерөнхий сайд хэлэхдээ "Хэнтий аймаг түүхэн аялал жуулчлалын төв болсон учраас Чингис хааны өлгий нутаг Дадал сум дэлхийн анхааралд өртөж, гадаад, дотоодын жуулчдын цуваа тасрахгүй. Иймээс томоохон Боинг 747 онгоц буухаар нисэх буудалтай байх учиртай. Тэгэхээр зураг төслөө боловсруулах, ТЭЗҮ гаргах шаардлагатай" гэдгийг захиж, ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ онгоцны буудал барих бололцоотой гэдгийг дуулгалаа.

Үүний дараа тэд Баян-Адарга сумын "Төмөр бетон гүүр"-ийн барилгын ажлын шав тавилаа. Хэнтий аймгийн ЗДТГ, Зам тээврийн хөгжлийн яамны захиалгаар улсын төсвийн 4.5 тэрбум төгрөгийн өртөгтэй, 150 метр урт гүүрийг "Ган гүүр" ХХК гүйцэтгэхээр шалгарсан байна. Гүүр, угсралтын ажил өнөөдрөөс эхэлж байгаа бөгөөд ирэх 11 дүгээр сард ашиглалтад орно. Ажлын явцад Зам, тээвэр хөгжлийн төв хяналт тавих ажээ.

Ерөнхий сайдаар ахлуулсан баг үргэлжлүүлээд Монгол их хатдын өлгий Баян-Адарга суманд ажиллалаа.

ХЭНТИЙ АЙМАГТ “ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ” 19 САЯ ДОЛЛАРЫН ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ

Азийн хөгжлийн банкны 38 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлээр Хөвсгөл, Хэнтий аймгийн бүс нутагт түүхэн аялал жуулчлал, тухайн нутгийн онцлогт тохирсон “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх” төсөл нээлтээ хийлээ. Уг төсөл 2019-2024 онд Хөвсгөл нуур болон Онон-Балжийн байгалийн цогцолборт газруудад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, хүртээмжтэй эдийн засгийн болон байгаль хамгааллын жишиг загварыг бий болгох зорилготой хоёр дэд төслийн хүрээнд хэрэгжих юм.

10 дугаар сарын 10-нд Хэнтий аймгийн Дадал суманд болсон төслийн нээлтэд УИХ-ын гишүүн, ЗГХЭГ-ын Дарга Л.Оюун-Эрдэнэ, БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямба, АХБ-ны Зүүн Азийн газрын Байгаль орчны ахлах мэргэжилтэн Марк Р.Безайн нар оролцсон юм.

“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх” Хэнтий дэд төслийн хүрээнд “Чингис хаан” аялал жуулчлалын цогцолбор, Дадал сумаас тус цогцолбор хүртэлх 2.6 км хатуу хучилттай авто зам болон 4.5 км хэлхээ цахилгаан дамжуулах шинэ шугам барих юм. Түүнчлэн хяналтын нэвтрэх цэгүүд, тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч бүхий 50 автобус, 220 автомашины хүчин чадалтай 3 авто зогсоол барих зэрэг томоохон бүтээн байгуулалт болон тусгай хамгаалалттай газрын менежментийг сайжруулах ажлууд хийх аж. Төслийн үр дүнд орон нутгийн иргэдийн аялал жуулчлалаас хүртэх үр өгөөж нэмэгдэж, аялал жуулчлалын дэд бүтэц, хог хаягдлын менежмент сайжирч, тогтвортой аялал жуулчлал хөгжих боломж бүрдэнэ гэдгийг албаныхан онцоллоо.

Ташрамд дурдахад Монгол Улсын Засгийн газар аялал жуулчлалын салбар нь эдийн засгийг төрөлжүүлэх, тэргүүлэх салбар мөн хэмээн тодорхойлсон. Энэ хүрээнд 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан юм.

WWW.E-KHUTUCH.MN ЦАХИМ ХУУДАСНЫ НЭЭЛТИЙГ ХЭНТИЙ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 50 дугаар тогтоолоор 2018 оны 2 дугаар сард баталсан билээ. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэх нэг гол ажил нь иргэд хүссэн цагтаа, хүссэн газраасаа шаардлагатай мэдээлэл авах, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө мэдээллийн баталгаатай эх сурвалж болох эрх зүйн цахим мэдээллийн сан “e-khutuch.mn” портал цахим хуудсыг бүтээж, ашиглалтад оруулах байсан.





Энэ хүрээнд хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим сан www.e-khutuch.mn, legalaids.mglbar.mn цахим хуудасны орон нутаг дахь нээлтийн ажиллагааг Хэнтий аймагт зохион байгуулж, тус аймгийн Нэг цэгийн үйлчилгээний төвийн өөртөө туслах танхимд "Эрх зүйн хөтчийн мэдээллийн булан"-г тохижууллаа. Энэ хүрээнд иргэдэд <http://legalaids.mglbar.mn/> цахим хуудсаар дамжуулан Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчид хууль зүйн анхан шатны зөвлөгөө, туслалцааг цахимаар үзүүлэх юм.

Хэнтий аймагт анх удаа жишиг байдлаар нээсэн энэхүү "Эрх зүйн хөтчийн булан"-гаас иргэд өөрийн оршин суугаа газрын эрх зүйн хөтөч нарын мэдээллийг авахын зэрэгцээ тус цахим хөтөч хуудсанд хандаж өөрт хэрэгтэй хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр авах боломжтой.

ЗҮҮН БҮСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХАД ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ НЬ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ



Монгол улсын Засгийн газраас АХБ-ны 600 мянган ам.долларын санхүүжилтээр Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт "Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь" төслийн нээлт 11 дүгээр сарын 25-ны өдөр боллоо

Төслийн нээлтэд ЗГХЭГ-ийн Орон нутгийн удирдлага, Зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямба, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар, Дорнод аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох, Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал Т.Дүүрэн, тус төслийн Орон нутгийн хөгжлийн мэргэжилтэн Ш.Алтанбадрал, зөвлөх эдийн засагч Гари Хо нар болон зүүн гурван аймгийн Төр хувийн хэвшлийн түншлэлийн төлөөллүүдийг хамруулсан 70 гаруй хүн оролцож байна.



Төслийн гол зорилго нь Зүүн бүсийн /уул уурхайн бүс/ хувийн хэвшлийн салбарын хөгжлийг дэмжих бодлогын бичиг баримт боловсруулах, өрсөлдөх чадварын судалгаа, бэлэн байдлын судалгаа хийж, судалгааны үр дүнд аймгуудыг тэргүүлэх бизнесийг тодорхойлох, бүсийн аймгуудын бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх, Орон нутгийн төрийн албан хаагчид, оролцогч хувийн хэвшлийн ажилтнуудад техникийн сургалт явуулахад чиглэгдэж байгаа юм.

"ЁОХОР ХАТАР-2019" АРДЫН УРЛАГИЙН НААДМЫН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО

Ардын уламжлалт урлагийг төрийн ивээлд байлгаж, тэдгээрийг судлах, сургаж эзэмшүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, соёлын өв тээгчдийг тодруулан алдаршуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор Буриад зоны эртний уламжлалт бүжгийн "Ёохор хатар 2019" наадмыг Хэнтий аймгийн Батширээт сумын ИТХ, ЗДТГ, "Батширээт Хөгжил Сан" ТББ-аас долдугаар сарын 16-19-ний өдрүүдэд зохион байгуулж, шилдгүүдээ шалгарууллаа. Буриад зоны уламжлалт тойрон бүжиг Ёохор наадмыг 2014 оноос санаачлан зохион байгуулсан

бөгөөд дөрөв дэх удаагийн наадамдаа Буриадын Хатар бүжгийн төрлийг нэмэгдүүлж, хоёр жилд нэг удаа зохион явуулах болсноороо онцлогтой.

Наадмын ерөнхий ивээн тэтгэгч, хамтран зохион байгуулагчаар БОАЖЯ, БСШУСЯ, Хэнтий аймгийн ЗДТГ оролцсон бөгөөд олон улсын чанартай тус наадамд ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын Агын тойрог, Могойтын район, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Дорнод аймгийн Дашбалбар, Баян-Уул сум, Хэнтий аймгийн Норовлин, Баян-Адрага, Дэлгэрхаан, Батноров, Батширээт сум, Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгоноос нийтдээ 12 хамтлагийн 300 гаруй ардын авьяастнууд оролцож, Буриад ардын уламжлалт болон орчин үеийн бүжгийн төрлөөр өрсөлдлөө.

“ЁОХОР ХАТАР-2019” наадмын шилдгийн шилдэг “Гранпри” шагналын эзнээр Хэнтий аймгийн Батширээт сумын “Тоонот” хамтлаг шалгарч, өргөмжлөл цом, 3 сая төгрөгийг Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямбаас гардан авлаа.

Наадмын уламжлалт бүжгийн төрлийн тэргүүн байранд ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын Могойтын Районы “Улаалзай” хамтлаг, Дэд байранд ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын Агын тойргоос оролцож буй “Түмэн жаргалан” хамтлаг, гуравдугаар байранд Улаанбаатар хотын “Ёохор Хатар” хамтлаг, тусгай байранд Хэнтий аймгийн Норовлин сумын “Мөнгөн Долгион 2” хамтлаг тус тус шалгарлаа.

Харин орчин үеийн бүжгийн төрлийн тэргүүн байранд Хэнтий аймгийн Норовлин сумын “Мөнгөн долгио 2” хамтлаг, дэд байранд Дорнод аймгийн Дашбалбар сумын “Дорнын солонго” хамтлаг, гуравдугаар байрт Хэнтий аймгийн Батноров сумын “Сарны эрх чөлөө” хамтлаг, тусгай байранд Хэнтий Дэлгэрхаан сумын “Гэрэлт-Ирээдүй” хамтлаг шалгарлаа.

Үзэгчдийн таашаалд нийцсэн хамтлагаар Дорнод аймгийн Баян-Уул сумын “Улзын шигтгээ” хамтлаг шалгарсан бол “Ёохор Хатар-2019” наадмын “НЭРЭМЖИТ ЦОМ”-ыг Зууны манлай бүжиг дэглээч Сэвжидийн нэрэмжит бүжгийн чуулгын дасгалжуулагч багш, МУГЖ Шагдарын Одонтуяа ардын дуу бүжгийн “Хан Хэнтий Чуулга”-д гардуулан өглөө.

Тус наадмын, дэмжигч байгууллагаар Монголын Буриадын төв холбоо, АДБ-ийн Хан Хэнтий чуулга, Соёлын өвийн төв, Соёл судлалын хүрээлэн, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, Буриад судлалын академи, Хэнтий аймгийн Ардчилсан нам оролцсон бөгөөд наадмыг 20 гаруй сая төгрөгийн төсвөөр зохион байгуулж төрөл тус бүрт нэгдүгээр байранд өргөмжлөл, алтан медаль нэг сая төгрөг, хоёрдугаар байранд өргөмжлөл, мөнгөн медаль, 700 мянган төгрөг, гуравдугаар байранд өргөмжлөл, хүрэл медаль, 500 мянган төгрөг, тусгай байранд өргөмжлөл, 200 мянган төгрөгөөр шагнаж урамшууллаа.





Ерөнхий шүүгчээр Үндэсний урлагийн их театрын Зууны манлай бүжиг дэглээч Сэвжидийн нэрэмжит бүжгийн чуулгын дасгалжуулагч багш, МУГЖ Шагдарын Одонтуяа, шүүгчдээр Буриад судлалын төвийн ерөнхийлөгч Л.Оюунцэцэг, СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал, доктор Ш.Эрдэнэцэцэг, Хан Хэнтий чуулгын уран сайхны удирдаач МУСТА Ц.Оюунбаатар, дуучин н.Нямдаваа нар ажиллаж, шүүн тунгаалаа.

Энэ жилийн “ЁОХОР ХАТАР -2019” наадмын хүрээнд Эрдэм шинжилгээний бага хурал, Буриад бөхийн барилдаан, Буриад сурын харваа, Хатар жороо морьдын уралдаан, сээр цохих, Тойрон хатар хийх, Буриад зоны аялгуу тоглолт зэрэг уламжлалт уралдаан наадмыг зохион байгуулж, наадамд оролцогчдоос гадна 1000 гаруй зочид төлөөлөгчдийг татсан өргөн дэлгэр наадам боллоо.

ЭЭШ-Д 800 ОНОО АВСАН СУРАГЧИД, СУРАГЧАА САЙН БЭЛДСЭН БАГШ НАРТ ТУС БҮР НЭГ САЯ ТӨГРӨГИЙГ ГАРДУУЛАН ӨГЛӨӨ



Аймгийн Засаг дарга Н.Ганбямбын санаачилгаар өнгөрсөн жил ЭЭШ-д 800 оноо авсан сурагчид, сурагчаа амжилттай бэлдсэн багш нарт тус бүр 500 мянган төгрөгийн урамшуулал үзүүлж байсан бол энэ жилээс 1.000.000 төгрөгийн урамшуулал үзүүлэхээр болсон.

Тэгвэл өнөөдөр амжилт үзүүлсэн Тэмүүжин цогцолбор сургуулийн Нийгмийн ухааны багш П.Эрдэнэцэцэг, нийгмийн ухааны хичээлээр 800 оноо авсан Тэмүүжин ЦС-ийн 12А ангийн суралцагч Э.Амирлан, Хан Хэнтий цогцолбор сургуулийн Монгол хэлний багш З.Чулуунцэцэг, Монгол хэлний хичээлээр 800 оноо авсан тус сургуулийн 12А ангийн суралцагч С.Сугар, Бэрх тосгоны нийгмийн ухааны багш Г.Бат-Учрал, нийгмийн ухааны хичээлээр 800 оноо авсан Бэрх тосгоны 12А ангийн суралцагч О.Отгончимэг нарт тус бүр нэг сая төгрөгийн батламжийг гардуулан өглөө. Мөн Тэмүүжин ЦС-ийн Математикийн багш Э.Батболд, математикийн хичээлээр 800 оноо авсан тус сургуулийн сурагч Г.Дармаабазар нарт батламжийг гардуулан өгөхөөр болов.



ЭЭШ-ын дүнгээр Хэнтий аймаг 2016 онд оролцогчдынхоо оноогоор Баян-Өлгий аймгийн өмнө буюу 20-р байранд бичигдсэн бол хоёр жилд найман байраар урагшилж өнгөрсөн жил 12-р байранд жагссан. Харин энэ жилийн урьдчилсан дүнгээр өнгөрсөн жилийн амжилтаасаа 10 байраар урагшилж, 2-р байранд жагсаж байна.

Энэ нь боловсролын салбартаа бодлогоор анхаарсан байдал, “Багшийн эрдэм шавиас” гэдэгчлэн, сурагчдын сурлагын чанарын үзүүлэлт багш нарын хичээл зүтгэлтэй холбоотой гэдгийг аймгийн дарга чухалчилж, 2019 оны ЭЭШ-д ихэнх шалгалтад Хэнтий аймгийн суралцагчид оноогоороо тэргүүлснийг онцоллоо.

БОР-ӨНДӨРИЙГ ТОЙРСОН ХЯТАДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ КОМПАНИУДАД АЙМГИЙН ДАРГААР АХЛУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ ГЭНЭТИЙН ШАЛГАЛТ ХИЙЖ, ЗАРИМЫНХ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООЛОО

Энэ оны дөрөвдүгээр сард Аймгийн Засаг дарга Н.Ганбямбаар ахлуулсан ажлын хэсэг Дархан, Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдэд гэнэтийн шалгалт хийлээ.

Гэнэтийн шалгалтыг Дархан сумын гуравдугаар багийн нутагт байрлах “Эрдэнэт хун” ХХК-ийн Хажуу улааны жонш баяжуулах, боловсруулах үйлдвэрээс эхлэв. Ажлын хэсэгт Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Ус цаг уур орчны шинжилгээний төвийн нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй баг явж, харьяалагдах чиглэлээрээ шалгалт хийлээ.

Тус үйлдвэрээс шалгалтын үеэр БНХАУ-ын долоон иргэнийг битүүмжилсэн өрөөнд нуусан байсныг тагнуулынхан илрүүллээ. Хятад ажилчид Монгол улсад аяллын визээр зорчсон хэрнээ үйлдвэрт ажиллаж байсан нь Цагдаагийн Газрын байцаагчийн шалгалт, хятад иргэдийн мэдүүлгээр тогтоогдов. Ажлын хэсгийнхэн өнөөдөр Прокурорын байгууллагад мэдүүлж, баривчилгаа хийж, Гадаадын иргэн харьяатын газарт шилжүүлэх аж. Харьяа газар нь тэднийг шалгаж, Монгол улсаас албадан гаргах ёстой.

Онцгой байдлын газраас тус баяжуулах үйлдвэр гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй, гал түймрээс урьдчилан сэргийлэх болон гал түймэртэй тэмцэх багаж, тоног төхөөрөмжүүд нь элэгдэж муудсан, ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт хийв. Гамшиг ослын үед ажиллах сургалт, сурталчилгааны төлөвлөгөөгүй, мэдэгдэхүүнгүй, ХАБ-ын зааварчилгаагүй, олон хүний амьд явах эрх зөрчигдөж байна гэж үзлээ.

Мэргэжлийн хяналтын шалгалтаар Баяжуулах үйлдвэрт суурилуулсан дөрвөн кранд үзлэг хийж, хоёр нь ачилт, хоёр нь тусгай зориулалтаар ажиллаж байна. Бичиг баримт, техникийн паспорт байхгүй, угсралт, суурилуулалтын актгүй гэж дүгнэв. Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгүй, 2019 оны менежментийн төлөвлөгөө батлагдаагүй, нийтдээ дөрвөн цооног гаргасан гэж мэдээлсэн ч, хоёр нь олдохгүй байна. Хаана байгаагаа ч хэлэхгүй байна гэлээ. УЦУОШТ-өөс лабораторид ашигласан усыг хаяж буй хонгил, баяжуулах үйлдвэрээс байгальд гаргасан ус, уурхайн ойр орчмын хөрснөөс дээж авч, шинжлэхээр болов.

Цаашлаад үйлдвэрийн ашиглалтын төлөвлөгөөгүй, химийн лабораторидоо тосны хүчил /oleic acid/, техникийн содыг /sodium carbonate/ ашиглах, экспортлох, импортлох, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй ч, өөр төрлийн химийн бодис илэрсэн зөрчил гарав.





Шалгалтын дүнгээр “Эрдэнэт хун” ХХК-ийн жоншны баяжуулах үйлдвэрээс бичиг баримт, үйл ажиллагаатай холбоотой олон төрлийн зөрчил илэрлээ гэж мэргэжлийн байгууллагууд үзэж, үйл ажиллагааг түр нь зогсоож буйгаа мэдэгдлээ. Баяжуулах үйлдвэрийн цахилгааныг салгаж лацдах, лабораторийг битүүмжлэх, гарал үүсэл нь тодорхойгүй химийн хорт бодисуудыг лабораториудад шинжлүүлэхээр хүргэх, нарийвчлан шалгах ажил үргэлжилж байна.

“Эрдэнэт хун” ХХК-ийн Баяжуулах үйлдвэрийн Монгол талын захирал Л.Энхцэцэг холбогдох бичиг баримт нь төв оффистоо бий гэх мэдээлэл тухай бүр хийж байв. Тиймээс Мэргэжлийн хяналтын газраас тус компанийн захирал н.Соёл-Эрдэнийг холбогдолтой бүх бичиг баримтаа яаралтай авчрах мэдэгдлийг хүргүүлж байна.

Хяналт шалгалтын ажлыг явуулахдаа ажлын хэсэг Ашигт малтмалын тухай, Байгаль орчны тухай багц хууль, Усны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Тэсэрч дэлбэрэх бодисын тухай, Тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулахаар Дархан, Бор-Өндөр сумдад үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагуудыг ийнхүү шалгаж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өчигдөр орой БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Жинтайхэ” ХХК-ийн хүдрийн баяжмалын үйлдвэрийг шалгалаа. Дүгнэлт хараахан гараагүй. Өнөөдөр Бор-Өндөрт үйл ажиллагаа явуулж байгаа хятадын уул уурхайн компаниудад шалгалт үргэлжилж байгаа. Энэ талаарх мэдээллийг бид эргэн мэдээлэх болно.

Харин 3-р сарын 16-нд Хятадын 100 хувийн хөрөнгө оруулалттай Нордвинд ХХК-ийн Бичигтийн уурхайд аймгийн Засаг даргаар ахлуулсан баг гэнэтийн шалгалт хийж, нэлээдгүй зөрчил илрүүлсэн. Ажлын хэсгийнхэн “Нордвинд” компанийг холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн гэж үзэн Цагдаагийн газарт шилжүүлсэн билээ.

ХЭРЛЭН СУМАНД 100 ОРТОЙ ЦЭЦЭРЛЭГ БАРЬЖ ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Засгийн газар болон Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар нь Арабын нэгдсэн Эмират улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтын ажиллагааны хүрээнд тус улсаас 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Хэрлэн суманд 100 ортой хүүхдийн цэцэрлэг барьж бэлэглэхээр болсон билээ.

Уг цэцэрлэгийн барилга угсралтын ажлын нээлт /2019.11.07/ болж, Эмират улсын элчин сайдын яамны төлөөлөл, аймаг, сумын удирдлага, барилгын гүйцэтгэгч “АТТА ЧР” ХХК-ийн төлөөллүүд оролцлоо. Энэхүү 100 хүүхдийн шинэ цэцэрлэг Чингис цамхаг буюу 16 давхар барилгын урд талд баригдаж байгаа бөгөөд ирэх оны зургаадугаар сарын дундуур ашиглалтад орж, 2020-2021 оны хичээлийн жилд анхны суралцагчдаа хүлээн авах юм байна.

“ХЭНТИЙД ҮЙЛДВЭРЛЭВ” БРЭНД ДЭЛГҮҮРИЙН НЭЭЛТ БОЛОО

Хэнтийд үйлдвэрлэсэн бэлэг дурсгалын зүйлс, гар урлал, талх, гурилан боов, даршилсан ногоо, савласан цагаан идээ, гарын саван гоо сайхны бүтээгдэхүүн зэрэг 40 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр “Хэнтийд үйлдвэрлэв” брэнд бүтээгдэхүүний дэлгүүр нээлтээ хийлээ.

Авто буудлын худалдааны төвд үүд хаалгаа нээсэн тус дэлгүүрийн нээлтэд аймгийн Засаг дарга Н.Ганбямба, ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, Хэнтий аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга Д.Батболд нарын төлөөллүүд оролцож, жижиг дунд бизнес эрхлэгч, өрхийн үйлдвэрлэгчидтэйгээ уулзаж, Хэнтийн Брэнд бүтээгдэхүүний лого, шошгоны уралдаанд тэргүүн байр эзэлсэн гэрэл зурагчин Г.Баясгалантөгсөд нэг сая төгрөгийн эрхийн бичгийг гардуулан өглөө.

Аймгийн хэмжээнд мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 47, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 31, туслах аж ахуй эрхлэгч 12, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 65, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 47, арьс, ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 19, барилгын материалын үйлдвэрлэл 10, хэвлэл, эх бэлтгэл 9, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 7, гар урлал бэлэг дурсгал 5, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 11, нийтдээ 267 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлдэг байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 12-р тогтоолоор Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Хэнтийн брэнд” дэд хөтөлбөрийг баталсан нь орон нутгийнхаа боломж, давуу талыг ашиглан байгальд ээлтэй шинэ болон уламжлалт, технологи, өрсөлдөх чадвар бүхий нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний санаачлагыг өрсөлдүүлэн шилдэг брэндийг шалгаруулж, дотоод, гадаадын зах зээлд нэвтрүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн хувьд бие даасан нутаг дэвсгэр болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршиж байна.





АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТАД 320 ГАРУЙ ХҮН ХАМРАГДЛАА

БОАЖЯ, Хэнтий аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний салбарын төрөлжсөн сургалт өнөөдөр өндөрлөж, Тогооч, зөөгч, Бареста, Бартендер, Өрөөний үйлчлэгч, Зочин хүлээн авагч, Хөтөч, тайлбарлагч мэргэжлээр 320 гаруй хүн мэргэшиж, сертификатаа гардан авлаа.

Монголын зочид буудлуудын холбоо, Барестагийн холбоо, Бартендерийн холбоо, Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо, ОУ-ын мэргэшсэн тогооч нарын баг тус сургалтыг “ХАМТДАА ХӨГЖЬЕ, ХАНДЛАГАА ӨӨРЧИЛБЕ” уриан дор удирдан таван өдрийн турш явуулжээ.

Энэхүү эрчимжүүлсэн богино хугацааны сургалтыг ОУ-ын стандартад нийцсэн адил хөтөлбөртэйгөөр, 21 аймаг, Улаанбаатар хотоос нийтдээ 13-15 мянган хүнийг хамруулах зорилтыг МУ-ын Засгийн газраас дэвшүүлсэн. Үр дүнд нь зочлох үйлчилгээний салбар хөгжин жуулчдад үзүүлэх үйлчилгээ, стандарт сайжирч жуулчид сэтгэл ханамжтай буцах нөхцөл бүрдэхээс гадна нийслэлийн болон орон нутгийн иргэд ажлын байртай болж орлогоо нэмэгдүүлэх ач холбогдолтой аж.

Сертификат гардуулах үеэр сургагч багш нар Хэнтий аймагт Мэргэжлийн зочлох үйлчилгээний болон Барестагийн мэргэжлийн сургагч багш нар бэлтгэж өгөх, Бартендерийн үйлчилгээг орон нутагтаа дэлгэрүүлээрэй хэмээж багаж, тоног төхөөрөмж гардууллаа. Түүнчлэн МСҮТ-ийн үйлчилгээний сургалтыг сайжруулахтай холбоотойгоор 2019-2020 оны хичээлийн жилд Зочлох үйлчилгээний, Хөтөч, тайлбарлагчийн мэргэжлийн ангийг ХНХЯ-ны харьяа Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газраас шинээр нээн ажиллуулах болсныг мэдэгдлээ.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ж.Ганбаатар цаашдаа жил бүр мэргэжлийн баг бүрэлдэхүүнийг урьж, ахисан төвшний сургалтуудыг орон нутагт авах сонирхолтой байгаагаа мэдэгджээ.

ХОВДЫН ТАРВАСЫГ ХЭНТИЙД НУТАГШУУЛЛАА

Ховдын тарвасыг Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Мөрөн, Хэрлэн, Норовлин зэрэг долоон суманд нутагшуулан тариалж эхэлсэн. Тэгвэл энэ жил Дэлгэрхаан суманд н.Амирхааны тариалж ургуулсан тарвасаар “Улаанбаатар Экспо” намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд тэргүүн байр эзэлсэн байна.



“МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО”-НЫ ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР ХОЛБООНЫ БАГА ХУРЛААР УДИРДАХ ЗӨВЛӨЛ, НАРИЙН БИЧГИЙН ДАРГАА СОНГОЖ, ЦААШДЫН АЖЛАА ТӨЛӨВЛӨВ

Цэрэг, эх оронч, үндэсний үзэл бахархлыг хөгжүүлэн, ард түмнээ соён гэгээрүүлж, Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлаа, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх үйлст төр, иргэний нийгмийн байгууллагууд, цэргийн үүрэгтнүүд, иргэдийг нэгтгэх зорилгоор 2019 оны 4 дүгээр сард тус тусдаа үйл ажиллагаа явуулж байсан цэргийн мэргэжлийн холбоодыг нэгтгэн “Монгол цэргийн нэгдсэн холбоо” Төрийн бус байгууллага үүсэн байгуулагдаж тэргүүнээр нь Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх сонгогдсон билээ. Улмаар өнгөрсөн 9 дүгээр сарын 06-ны өдөр “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны Хэнтий аймаг дахь салбар холбоог байгуулж Тэргүүнээр аймгийн Засаг дарга Н.Ганбямба сонгогдсон

Тэгвэл /2019.11.15/ “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны дүрмийн дагуу сум бүрээс гурваас доошгүй бэлтгэл офицер, ахлагч, цэргийн үүрэгтэн төлөөлөгчдийг урьж, 80 шахам хүний бүрэлдэхүүнтэй Хэнтий аймаг дахь салбар холбооны бага хурлаа зохион байгууллаа. Хурлын зохион байгуулалтыг аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас зохион байгуулсан бөгөөд /удирдах зөвлөл, НБД сонгогдтол/ бага хурлаар салбар холбооны үйл ажиллагааг шууд удирдан зохион байгуулах Удирдах Зөвлөлийг гишүүдээрээ хэлэлцэн сонгож, нарийн бичгийн даргаа томилон, гишүүддээ дүрмээ танилцууллаа. Үүнчлэн гишүүдтэйгээ зохион байгуулалт, гишүүнчлэл, ажлын байр, төсвийн талаар санал солилцож, бага хурлаа өндөрлүүлээ.

Салбар хорооны удирдах зөвлөлийн гишүүдээр Бэлтгэл хурандаа Д.Сайнболд, Бэлтгэл хурандаа Д.Батжаргал, Бэлтгэл дэд хурандаа Д.Дангаасүрэн, Бэлтгэл дэд хурандаа Д.Ганхуяг, Бэлтгэл дэд хурандаа Ш.Ганбат, Б/Х Н.Ганпүрэв, Б/А Р.Ганхүү, Б/А Д.Борхүү, Б/А С.Наранбадрал, Б/Д Ш.Отгонжаргал, Б/Д А.Даваадорж, Б/Д М.Ган-Эрдэнэ, Б/Д Г.Болд, Б/Т Р.Бадрах, Б/Т Р.Сүхбаатар, Б/Т П.Энх-Амгалан нар 100 хувийн дэмжлэг аван сонгогдлоо. Түүний дараа удирдах зөвлөлийн гишүүд нарийн бичгийн даргаа хэлэлцэж, Цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Цэдэндамбын Батсайхан сонгогдлоо.

Монгол цэргийн нэгдсэн холбооны Хэнтий аймаг дахь салбар холбоо нь Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас тэтгэвэр чөлөөнд гарсан болон одоо алба хааж байгаа бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, энхийн бүтээн байгуулалтад гавьяа байгуулсан төр, цэрэг, цагдаагийн албан хаагчид хөдөлмөр, соёл урлаг, шинжлэх ухааны зүтгэлтэн, иргэдийг алдаршуулах, түүхэн тэмдэглэлт үйл явдлуудын үеэр хүүхэд залуучуудыг соён гэгээрүүлэх зэрэг төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.





ТӨРИЙН 10 БАЙГУУЛЛАГЫГ ШИНЭ БАЙРТАЙ БОЛГОВ

Хэнтий аймагт 2016-2019 онд Нэгдсэн эмнэлэг, ГХБХБГ, Бэрх тосгоны аврах гал унтраах барилга, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Авто тээврийн төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Тагнуулын хэлтэс, Татварын хэлтэс, Цагдаагийн газрын шинэ барилгыг ашиглалтад

оруулсан. Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын иргэдэд үйлчлэх төвийн барилга энэ сард ашиглалтад орно. Ингэснээр төрийн 10 байгууллагыг шинэ байртай болгож төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ая тухтай хүргэх орчин нөхцлийг сайжрууллаа.



● 2017 ОНД


1. Өндөр хүчдэлийн шонгууд, дамжуулах шугам
2. Баянмөнх сумын гүүр – 3,8 тэрбум
3. Хэрлэн 1 дүгээр сургууль
4. Батширээт сумын 320 хүүхдийн сургууль -1.0 тэрбум
5. ТОСК-ийн 120 айлын орон сууц
6. 8,4 мегаваттын уурын зуух
7. Биндэр сумын 640 хүүхдийн суудалтай сургууль - 2,6 тэрбум
8. Хямд үнэтэй 48 айлын орон сууц
9. Нэгдсэн эмнэлгийн барилга -16,5 тэрбум
10. Мянган нуурын хотгор 1,3 дугаар багийн гэр хорооллын хонхор хотгор тэгшлэх -60 сая
11. 2, 4 багийн ЦДАШ – 40 сая
12. Чандганы зам -7,5 тэрбум
13. Дадал сумын цагдаагийн кабон-30 сая
14. Цагдаагийн конторын барилгын зураг төсөв – 37,7 сая
15. ГХБХБГазрын офиссын барилга, барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори -719,3 сая
16. Цэнхэрмандал сумын нутагт “Зам тээврийн хяналтын төв”- 85 сая
17. Цэнхэрмандал сумын ЭМТөвийн барилгын цахилгааны их засвар- 80,0 сая
18. Бэрх тосгоны 500 айлын нийтийн орон сууцны 650 метр ус, дулаан хангамжийн шугамын шинэчлэл -316,2 сая
19. “Биндэр шинэ сум”-
20. “Сумын шинэ төв” Баян-Адрага сумын дулаан хангамжийн шугам сүлжээ- 400 сая
21. Хээрийн сургалт дадлагын төв -
22. Шүүхийн шинжилгээний албыг байртай болгоход дэмжлэг - 20,0 сая
23. Хэрлэн сумын төвийн 6 багийн 16 байршилд цамхагт гэрэл - 64 сая
24. Аврага тосон дахь ахмадын сувилалын өргөтгөл – 33,0 сая
25. Хэрлэн сумын 2, 4 дүгээр багт шинээр олгосон газруудыг цахилгаан эрчим хүчээр хангах- 40 сая
26. Өмнөдэлгэр, Биндэр сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамыг бүрэн шинэчилсэн - 457,6 сая
27. Биндэр сумын эрүүл мэндийн төвийн цахилгааны их засвар -80.0 сая
28. Өндөрхаан нисэх буудлын зураг төсөл
29. Хэрлэн сумын 2,3 дугаар багт Ухаалаг худаг -24 сая
30. Ноосны үйлдвэр, махны үйлдвэр
31. Элит мандал зоогийн газрын барилга
32. Мөнхшувуут дэлгүүрийн барилга
33. Батширээт сумын 10 айлын орон сууц





● 2018 ОНД

1. Бэрх тосгоны аврах гал унтраах барилга -2,089,4 тэрбум
2. Автотээврийн төв -2,6 тэрбум
3. Ахмадын ордон- 250 сая
4. Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга -726 сая
5. Татварын хэлтсийн барилга- 1,350 тэрбум
6. Тагнуулын хэлтсийн байр
7. ШШГГ-ын “Нэг цэгийн үйлчилгээ”-ний барилгад дэмжлэг- 35,0 сая
8. Норовлин суманд 2, Биндэр суманд 1, Батноров суманд 1 багийн төв
9. Баян-Овоо суманд 120 ортой дотуур байр-1,45 тэрбум
10. Мэргэжлийн хяналтын газрын барилгын их засвар- 107,3 сая
11. Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, ус зайлуулах шугам-150 сая
12. Чингис хотын үерийн далан -120,0 сая
13. Бор-Өндөр сум, Бэрх тосгоны Нийтийн эзэмшлийн орон сууц, байруудын дээврийн засвар – 700,0 орчим сая
14. Чингис хот 2,5 болон Дэлгэрхаан /1,5/, Цэнхэрмандал/1,5/, Өмнөдэлгэр /1,8/ сумдад 120-200 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгууд- 7,3 тэрбум
15. Батноров сумын цэцэрлэгийн их засвар -80 сая
16. Баян-Овоо сургуулийн засвар 94 сая, Хэрлэн сум 4-р сургуулийн засвар -184 сая,
17. Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэгийн засвар -15 сая
18. Хурх тосгоны сургуулийн барилгын их засвар-200 сая
19. Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилгын их засвар-58,5 сая
20. Бор-Өндөр /480/, Дархан /80/, Дэлгэрхаан /40/, Жаргалтхаан /194,8/, Бэрх /100/, Хурх /45/ тосгоны соёлын төвийн барилгын их засварууд /939 сая/
21. Онон голын төмөр бетон гүүрийн засвар -2,4 тэрбум
22. Хурх тосгоны Эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн их засвар /45 сая/
23. Хямд үнэтэй 48 айлын орон сууц
24. Дулааны станц
25. Өндөрхаан нисэх буудал -3,5 сая доллар
26. Цэвэрлэх байгууламж
27. Хэрлэн сумын 1-5 дугаар багуудын хонхор, хотгорыг тэгшлэх- 230 сая
28. Хэрлэн сумын 1-6 дугаар багуудад цамхагт гэрэлтүүлэг-128 сая
29. Хэрлэн сумын орон сууцнуудын дээвэр, орцны засвар – 212,0 сая
30. Хэрлэн сумын 4,5-р багийн Өрхийн эрүүл



- мэндийн төвийг дулааны шугамд холбох -35 сая
31. Хэрлэн сумын 2,3,5 дугаар багуудад 5 худагт ухаалаг систем- 40 сая
 32. Хэрлэн сумын 2, 4-р багуудад шинээр олгосон газруудыг цахилгаан эрчим хүчээр хангах -35 сая
 33. 9 сумын агаарын шугамын шинэчилэл -1040.0 сая
 34. Хурхын голын модон гүүр - 78,5 сая
 35. Галшар сумын спорт залны барилгын их засвар - 50 сая
 36. 3 дугаар багийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт
 37. Наадмын талбайн засвар -
 38. Гэрэлт цэцэрлэгт хүрээлэн
 39. Өмнөдэлгэр сумын хөв цөөрөм- 600 сая
 40. Чингис хотын цэвэр усны гол шугамыг шинэчлэх /50 хувь/ -950.5 сая
 41. Хэрлэн сумын нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, ус зайлуулах шугам /50 хувь/- 150 сая
 42. Хэрлэн суманд цамхагт гэрэлтүүлэг -64 сая
 43. Ухаалаг худаг 1,5 дугаар баг -16 сая
 44. Цэнхэрмандал сумын шалган нэвтрүүлэхийн гаднах тохижилт- 42,9 сая
 45. Баян-Овоо, Өмнөдэлгэр сумын ИШС-г шинэчилсэн- 420 сая
 46. 4, 5 дугаар багийн өрхийн ЭМТ-ийг дулааны шугамд холбох- 35,0 сая
 47. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар- 300,0 сая
 48. АЗДТГ-ын барилгын засвар- 339,0 сая
 49. 2 дугаар багийн төвийн гадна ИШС, цахилгаан, холбоо- 50,7 сая
 50. Нэгдсэн эмнэлгийн хуучин байр буулгах-67,0 сая
 51. Баянмөнх сумын ЭМТ-ийн өргөтгөл, засвар -28,0 сая
 52. Тэмүүжин сургуулийн барилгын дээврийн засвар -40,0 сая
 53. Бэрх орон сууцны дээврийн засвар- 53,2 сая
 54. Шинэ Өндөрхаан хорооллын гадна холбоожуулалт- 70,0 сая
 55. Хэрлэн сумын 1 дүгээр сургууль, 1 дүгээр цэцэрлэгийн ус, ариун цэврийн байгууламжийг сайжруулах, засварлах- 39,8 сая
 56. Хэрлэн голын гүүрний постны зогсоол -25 сая
 57. Авто тээврийн урд талын зам засвар- 70 сая
 58. Норовлинд 40 ортой дотуур байр /өвсний үндэс/-179,95 сая

● ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Хэрлэн сум Хүдэрбаатарын авто угаалгын төв- 300 сая
2. Бэрх Хаан банкны тооцооны төв /95 хувь/- 164 сая
3. Баян-Овоо төрийн банкны тооцооны төв /95 хувь/-111,0 сая
4. Органик хүнс ХХК махны үйлдвэр- 245 сая
5. Түмэндэмбэрэл хайрхан ХХК махны үйлдвэр -650,0 сая
6. “Хэрлэн зоог”-ын барилга 250, сая





7. Дадал сумын ЦДАШ-ыг солих, тоолуурыг нэгдсэн шитэд холбох- 310,6 сая
8. Бор-Өндөр сум "Шилийн цахир" ХХК Чулуу бутлах үйлвэрийн барилга, гаднах цахилгаан хангамж- 650,0 сая

● 2019 ОН

1. 2 дугаар багийн төв - 220 сая
2. Цагдаагийн газрын барилга -2.040 тэрбум
3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын иргэдэд үйлчлэх төвийн барилга /40 хувь/ - 1,5 тэрбум
4. Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн" цогцолборын барилга /10 хувь/ – 2 тэрбум
5. "Хүлэгбаатар Боорчи-Андлалын Өргөө" цогцолборын барилга /35 хувь/ – 2 тэрбум
6. "Шихихутаг нууц товчоо" түүхэн аялал жуулчлалын цогцолборын барилга / Норовлин сум/ - 1.5 тэрбум
7. Галшар, Дадал, Дархан Цэнхэрмандал сумын ЗДТГ-ын барилга - 4,2 тэрбум
8. 1 дүгээр багийн дахин төлөвлөлт -650 сая
9. Өмнөдэлгэр сумын төвийн гадна дулааны сүлжээ, зуухны дуусгал- 1,2 орчим тэрбум
10. Бэрх тосгоны сургуулийг олон улсын стандартад нэвтрүүлэх-1,0 тэрбум
11. Баян-Адрага сумын "Төмөр бетон гүүр" / шав тавьсан/- 4,5 тэрбум
12. 100-150 ортой дотуур байрын барилга / Баян-Адрага, Бэрх, Дадал/ -4,2 тэрбум
13. Дэлгэрхаан сумын сургуулийн спорт заалын өргөтгөл- 1,2 орчим тэрбум
14. Баян-Овоо, Норовлин суманд 100-200 ортой Цэцэрлэг-3,2 тэрбум
15. Баян-Адрага сум цэцэрлэгийн өргөтгөл - 700 сая
16. Галшар сум сургуулийн барилгын их засвар -200.0 сая
17. Өмнөдэлгэр сумын соёлын төв- 3,5 тэрбум
18. Батноров, Биндэр сумын Соёлын төвийн барилгын их засвар -388,2 сая
19. Баянхутаг сумын спорт заалын барилга -750.0 сая
20. Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам - 10,0 тэрбум
21. Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн хатуу хучилттай авто зам-49,3 тэрбум
22. Өмнөдэлгэр сумын доторх хатуу хучилттай авто зам -2,5 тэрбум
23. Чингис хот-Бэрх чиглэлийн аялал хатуу хучилттай авто зам-20,0 тэрбум
24. Баян-Адарга сумын Онон голын төмөр бетон гүүр- 4,5 тэрбум
25. Дадал сумын Онон голын төмөр бетон гүүрийн засвар- 2,4 тэрбум гаруй
26. Баян-Адрага, Норовлин сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга- 640 сая
27. Хэрлэн сумын Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл - 700.0 сая
28. Нийтийн тээврийн Монголд үйлдвэрлэсэн цахилгаан автобус - 450.0 сая
29. 4 дүгээр багийн ахуй үйлчилгээ/-67,9 сая
30. Дадалын цэргийн ангийн эмнэлэг – 60 сая
31. ШШГГ-ын ажилчдын хүүхдийн цэцэрлэг
32. Хэрлэн сумын 6 дугаар багт 30 хүүхдийн цэцэрлэг

